

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН
2020 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2020.02.04

Сүхбаатар сум

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны талаар

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны анхдугаар хуралдаан 01 дүгээр сарын 15-ны өдөр хуралдаж, доорх асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

2020 онд иргэдэд өмчлүүлэх газрын зориулалт, байршил, хэмжээг сум тус бүрээр, аймгийн нутаг дэвсгэрээс 2020 онд ойгоос нэмэлтээр бэлтгэх хэрэглээний модны хэмжээг нэмэлтээр, Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг 2020-2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, аймгийн 2019 оны төсөвт тусган аймгийн Засаг даргын захиалгаар Байгаль орчны мэргэжлийн байгууллага “Агнуур судлалын нийгэмлэг” төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлсэн Сэлэнгэ аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалтын ажлын тайлан, ан агнуурын менежментийн төлөвлөгөөг дэмжлээ.

Мөн “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр” болон “Авлига, ашиг, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг хэлэлцэж, “Хангалттай” гэж дүгнэлээ.

Төр, нийгмийн ахмад зүтгэлтэн, эдийн засгийн ухааны дэд эрдэмтэн, багш Тамжавын Бямбаагийн Монгол Улсын боловсролын салбарт байгуулсан гавьяа зүтгэл, хөдөө аж ахуйн боловсон хүчин бэлтгэх үйлсэд гаргасан амжилт, хөдөлмөрч чанарыг нь залуу хойч үедээ үлгэр дуурайлал болгон мөнхжүүлэх зорилгоор Ерөө сумын Ерөнхий боловсролын сургуулийг тус сумын уугуул, анхны төгсөгч, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт, Ардын Их Хурлын Депутат асан Тамжавын Бямбаагийн нэрэмжит болголоо.

Боловсрол, соёл урлаг, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан Сэлэнгэ аймгийн харьяат зарим иргэдийг одон, медалиар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжиллаа. Үүнд: Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 1, Алтан гадас одонгоор 5, Хөдөлмөрийн хүндэт медалиар 26 хүнийг тус тус шагнуулахаар уламжлав.

2.Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар

Аймгийн Засаг дарга Ш.Оргил 2020 оны 01 дүгээр сарын 16, 17-ны өдрүүдэд Сайхан, Орхон, Сант сум, Номгон тосгонд ажиллаж, ард иргэдтэй уулзан 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагаа, нөхцөл байдал, хөрөнгө оруулалтын ажлын үр дүнтэй танилцаж, зарим асуудлыг газар дээр нь шийдвэрлэж ажиллалаа. Аймгийн Засаг даргатай холбогдох газар, хэлтэс, албадын дарга нар ажилласан бөгөөд тухайн сум орон нутагт шаардлагатай байгаа зарим асуудлуудыг шийдвэрлэлээ. Тухайлбал: Сайхан сумын Номгон тосгоны Эрүүл мэндийн төв нь өвчтөн хүлээн авах боломжгүй талаар мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарсан тул шинэ эмнэлгийн зураг төсвийг хийлгэх талаар холбогдох хэлтэст чиглэл өгч, цэцэрлэгийн хүүхэд багачуудыг эрүүл хүнсээр хангах гал тогооны зарим хэрэгсэл, соёлын төвд ЛЕД дэлгэц, Орхон суманд эмнэлгийн үйл ажиллагаанд нэн шаардлагатай биохимийн анализатор, зүрхний цахилгээн бичлэгийн аппарат, хүүхэд, том хүний пульсоксметр 6 ширхэгийг, сумын соёлын төвд 5 ширхэг морин хуур, Сант суманд эрүүл мэндийн төвд шаардлагатай аппарат, тоног төхөөрөмж, ЕБС-д электрон

самбар олгох гэх мэт асуудлуудыг шийдвэрлэхээр боллоо.

БНХАУ-д гарсан шинэ коронавирусийн халдварын эрсдлийг бууруулах чиглэлээр Монгол Улсын Засгийн газар, Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулж буй арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлэх, орон нутгийн бэлтгэл бэлэн байдлыг хангах, иргэдийг мэдээллээр хангах зорилгоор Аймгийн Онцгой комиссын хурлыг аймаг, сумдын онцгой комиссын гишүүдийг оролцуулан өргөтгөсөн байдлаар цахим хэлбэрээр 1 дүгээр сарын 31-ний өдөр зохион байгуулж, холбогдох газруудад үүрэг чиглэл өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын дагуу Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2019 оны жилийн эцсийн тайланг нэгтгэн Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний “Unelgee.gov.mn” цахим сайтаар дамжуулан тайлагналаа. 2019 оны жилийн эцсийн байдлаар уг цахим сайтад байршуулсан аймагт хамааралтай тогтоол шийдвэрийн 143 заалтын хэрэгжилтийг 96,0 хувьтайгаар тайлагнасан. Мөн Монгол Улсын Засгийн газраас 2019 оны зарласан “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний аймагт хамааралтай 32 заалтын хэрэгжилтийг 91,4 хувьтайгаар тайлагналаа. Мөн 2019 онд аймгийн хэмжээнд төрийн байгууллага, албан тушаалтанд нийт 5918 иргэн хандаж санал, хүсэлт, өргөдөл, гомдол гаргаснаас 5648 иргэний өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн нь 95.4 хувийн гүйцэтгэлтэйгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь хүргүүлж ажиллалаа.

Аймгийн хэмжээнд халаалтын зуухын 16,536 тонн буюу нийт 17 хоногийн нүүрсний нөөцтэй хэвийн горимоор үйл ажиллагаа явагдаж, одоогоор эрчим хүчний доголдол, саатал гарсан зүйлгүй хэвийн байна.

Аймгийн хэмжээнд 17 сумын 56 багт нийт 8896 малчин болон мал бүхий өрхөд 1.5 сая толгой мал өвөлжихөөр тоологдож, сумдын өвс тэжээлийн нөөцийн бүрдүүлэлт 86 хувь, аймгийн өвс тэжээлийн нөөцийн бүрдүүлэлт 100 хувьтай байна.

“Нутгийн захиргааны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөлт” сэдэвт сургалтыг Удирдлагын академитай хамтран энэ сарын 15-17-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтанд аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын нэгжийн дарга, ахлах мэргэжилтнүүд, аймгийн Боловсрол, соёл урлагийн газар, Эрүүл мэндийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Байгаль орчин аялал жуулчлалын газрын холбогдох мэргэжилтнүүд хамрагдлаа.

Мэргэжлийн хяналтын газрын ажил үйлчилгээний талаар

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 1 дүгээр сарыг “Дотоод ажлыг сайжруулах сар” болгон зарлаж, дараах ажил арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа. Үүнд:

-Улирлын чанартай томуу, томуу төст өвчин бусад амьсгалын замын цочмог халдварт өвчний гаралт ихсэж байгаатай холбогдуулан боловсролын 3 байгууллад төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж нийт 19 зөрчил дутагдлыг илрүүлж, 8 зөрчлийг арилгуулж, зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр улсын байцаагчийн 18 заалттай 3 албан шаардлагыг гарган хүргүүлж, Зөрчлийн тухай хуулиар 3 албан тушаалтан хариуцлага тооцуулах тухай саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэн ажиллалаа.

Аймгийн хэмжээнд халаалтын зуух ажиллуулж буй 15 аж ахуйн нэгжид хяналт шалгалтыг хийж улсын байцаагчийн хамтарсан зөвлөмжийг холбогдох аж ахуй нэгж болон сумдын Засаг дарга нарт хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Сэлэнгэ аймгийн Түшиг сум, Булган аймгийн Сэлэнгэ сумын нутгийн залгаа Зэд Бүтээлийн нурууны улсын тусгай хамгаалалттай газраас Түшиг сумын нэр бүхий иргэд хууль бусаар зэрлэг гахай, загас агнасан зөрчлийг Хилийн цэргийн

0243 дугаар ангиас ирүүлснийг харъяаллын дагуу Булган аймаг руу шилжүүлэн ажиллалаа.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Хөтөл, Сэлэнгэ салбаруудад 2019 оны ургацаас хүлээн авч нөөцөлсөн 8241 тонн хүнсний улаанбуудай, 1055 тонн 3 сортын үрийн улаанбуудайнаас зохих журмын дагуу нийт 116 дээж авч лабораторийн шинжилгээнд хамруулан, шинжилгээний дүнг үндэслэн улсын байцаагчийн 4 заалттай 2 дүгнэлт гарган хүргүүллээ.

Мэргэжлийн хяналтын байгууллагаас 2020 оны 01 дүгээр сарын 10-нд хуулиар эрх олгогдсон улсын байцаагчдын уулзалт зөвлөгөөнийг зохион байгууллаа. Зөвлөгөөнд Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын захиргааны улсын байцаагчид, БОАЖГ-ын улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагчид, авто тээврийн хяналтын улсын байцаагчид болон сумдын Байгаль орчин, мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчид оролцсон бөгөөд дээрх улсын байцаагчидтай хариуцлагын гэрээ байгуулан ажиллаж байна.

Мөн “Хамтын хяналт”, “Ногоон карт” арга хэмжээг шинээр санаачлан олон нийтийн цахим сүлжээгээр буюу “Эрүүл хүнс сонголт таны гарт” преиймийг сурталчлан ажиллаж байна.

2020 оны 01 дүгээр сард зөрчлийн 4 хэрэг нээж хуулийн хугацаанд нь аймгийн прокурорын хяналтан дор бүрэн шийдвэрлэн ажиллалаа.

Итгэмжлэгдсэн лабораториос нийт 40 аж ахуйн нэгжийн 151 дээжинд 825 үзүүлэлтээр шинжилгээ хийхэд 6 аж ахуйн нэгжийн 33 дээж 54 үзүүлэлтээр буюу шинжилсэн дээжийн 21.9 хувь нь зэрэг гарлаа.

Стандартчилал, хэмжил зүйн хэлтсийн үйл ажиллагааны талаар

Стандарт, хэмжил зүйн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн 2020 оны 01 сарын 23-24-ны өдрүүдэд “Өөрчлөлт шинэчлэлийн жил 2020” уриан дор зохион байгуулагдсан бөгөөд зөвлөгөөн хэлтсийн дарга оролцож, “2019 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, тулгамдаж буй асуудал”-ын талаар мэдээлэл хийж, байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, баталгаажууллаа.

Стандартчилал, тохирлын үнэлгээ, баталгаажуулалтын чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Үйлчилгээний баталгаажуулалт:

Сүхбаатар, Жавхлант, Алтанбулаг, Сант, Мандал, Баянгол, Орхон сумдын 10 аж ахуйн нэгж, иргэний 3 хүнсний дэлгүүр, 3 минимаркет, 1 караоке баар, 1 цайны газар, 1 дэн буудал, 1 үсчний салоны үйлчилгээнд МУ-ын “Худалдааны газар, түүний үйлчилгээ үндсэн шаардлага MNS 5021:2007”, “Хоолны газрын ангилал, зэрэглэл. Үндсэн шаардлага MNS 4946:2005”, “Үс засах үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5160:2002”, “Аялал жуулчлал. Дэн буудал. Ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлагын дагуу тохирлын үнэлгээ хийж, тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаатай олголоо.

Мөн Ерөө, Мандал, Сүхбаатар, Хүдэр сумын нийт 14 аж ахуйн нэгж, иргэний 16 үйлчилгээний газарт тохирлын үнэлгээ хийж стандартын шаардлага хангасан 12 иргэн ААН-ийн 14 үйлчилгээний газарт аймгийн орон тооны бус баталгаажуулалтын салбар зөвлөлийн хурлын шийдвэрээр 1 спорт клуб, 1 минимаркет, 8 хүнсний дэлгүүр, 2 зоогийн газар, 1 зочид буудал, 1 дэн буудалд тохирлын гэрчилгээ олгосон.

Бүтээгдэхүүн баталгаажуулалт

Мандал сумын Түнхэл тосгоны “Түнхэл” талхан цехийн үйлдвэрлэсэн жижиг талх, Шаамар сумын “Аргангат” ЗГБХН-ийн үйлдвэрлэсэн зөгийн бал, Сүхбаатар сумын “Өгөөж Ундрам” цехийн үйлдвэрлэсэн “Өег” талх, “Кремтэй булочка”, “Амтлаг” талх, жигнэсэн гурил, Сайхан сумын Номгон тосгоны “Номгон хүнс” цехийн үйлдвэрлэсэн “Содон” нэрийн кимчи зэрэг 4 нэрийн 10 бүтээгдэхүүнийг МХГ-ын итгэмжлэгдсэн лабораторит сорилт шинжилгээнд оруулж, шинжээчийн дүгнэлт

гаргасан бөгөөд бүтээгдэхүүний сав баглаа боодол, хаяг шошгыг стандартын шаардлага хангасан зөв мэдээллээр хангаж арга зүйн заавар зөвлөмж өглөө.

Стандартын салбар сан:

Тус сангаас 5 аж ахуй нэгж байгууллага, иргэний захиалгын дагуу 5 нэрийн 7 стандартаар хангаж, арга зүйн зөвлөгөө өгч, үйлчилгээ үзүүлж ажиллалаа.

Хэмжил зүйн лабораторийн ажил, үйлчилгээ

Эзлэхүүн хэмжлийн төрлөөр Хөтөл тосгонд шинээр ашиглалтанд орж буй Хөрс шатахуун түгээх станцын хэмжих хэрэгслийг, механик хэмжлийн төрлөөр Сүхбаатар сум дахь худалдаа үйлчилгээнд ашиглаж байгаа 41 жин, 10 туухайг мөн уул уурхайн зориулалтаар ашигладаг 1 авто машины жинг шалган баталгаажуулалт хийсэн. Мөн сорилт шинжилгээний болон, зээлдүүлэх газрын 4 электрон жинд шалгалт тохируулга хийлээ.Цахилгааны хэмжлийн төрлөөр 1 фазын 2109 ширхэг тоолуур шалган баталгаажуулсан.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Өнгөрсөн сард 22781 баримтаар 96,6 тэрбум төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэлээ.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

/2019 оны 12-р сарын гүйцэтгэлээр/

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1. Орон нутгийн төсвийн нийт орлого		79,538,439,5	78,487,974.0	98.7
1.1	Орон нутгийн төсвийн орлого	21.186.430.7	21.360.123.6	100.8
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	15.297.336.3	15.638.601.8	96.0
	Сумдын төсвийн орлого	4.889.094.4	5.721.521.8	117
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	5.461.765.7	5.461.765.7	100.0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	44.759.089.8	44.618.501.2	99.7
1.4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	6.187.950.7	5.795.745.9	93.7
1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/			
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	131.825.9	131.825.9	100.0
1.7	Төсөвт байгууллагын өөрийн орлого	449.518.6	217.456.1	48.4
1.8	Сум хөгжүүлэх сан /орлого/	1.361.858.1	902.555.5	66.3
2. Орон нутгийн төсвийн нийт зарлага		96.257.806.6	91.623.776.0	95.2
2.1	Орон нутгийн төсвийн нийт зарлага	96.257.806.6	91.623.776.0	95.2
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	18.648.537.7	16.224.270.5	87.0
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	2.440.590.3	2.115.236.3	86.7
	Сумдын сум хөгжүүлэх сан	1.614.496.5	995.240.5	61.6
	Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага	26.726.943.6	25.132.477.9	94.0
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	600.000.0	595.901.4	99.3
	Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалт	549.000.0	262.679.6	47.8
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	3.474.464.5	2.900.157.5	83.5
	Халамжийн сан	278.690.0	175.270.0	62.9
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	21.396.989.1	20.831.688.6	97.4
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	427.800.0	366.780.8	85.7
	Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	50.074.670.4	49.459.967.7	98.8
	Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	807.654.9	807.049.9	99.9

3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		58.626.247.2	58.497.438.2	99.8
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	13.737.593.9	13.737.593.9	100.0
3.2	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	2.504.161.5	2.484.807.7	99.2
	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	129.563.5	141.343.1	109.1
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд			
	Хөрөнгө оруулалтын зардалд	2.362.818.4	2.343.464.6	99.2
3.3	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	3.683.789.2	3.310.938.2	89.9
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	3.342.638.6	2.969.787.6	88.8
	Усны татаас	21.650.6	21.650.6	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд	319.500.0	319.500.0	100.0
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	43.951.434.9	43.810.846.3	100.0
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	807.654.9	807.654.9	100.0
3.6	Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/	44.759.089.8	44.618.501.2	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	24.253.783.4	24.126.180.3	99.5
	- Хүүхдийн цэцэрлэг	12.880.315.6	12.877.674.2	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	6.691.473.0	6.681.128.9	99.8
	- Газрын кадастрын байгууллага	640.344.4	640.344.4	100.0
	- Хүүхдийн байгууллага	293.173.4	293.173.4	100.0
4. Тусгай сангуудын зарлага				
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	1.614.496.5	995.240.5	61.6

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл	2018 12- сар	2019 12- сар	2019- 12 2018-12 Х/төгрөгөөр/
1.ХҮНСНИЙ БАРАА			
1 ТАЛХ, ГУРИЛ, БУДАА			
Гурил /савласан, кг/	1 100	1 200	109.1
Талх /орон нутгийн, ш/	1 100	1 200	109.1
Нарийн боов /кг/	2 500	2 500	100.0
Будаа /кг/	2 400	2 400	100.0
Элсэн чихэр /кг/	2 200	2 200	100.0
2 МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
Хонины мах /кг/	5 500	6 500	141.8
Үхрийн мах /кг/	6 500	7 500	130.8
Адууны мах /кг/	5 800	6 500	112.1
Ямааны мах /кг/	5500	6 500	118.2
Дотор мах, цувдай /цусгүй/	3000	4 000	133.3
Хиам /чанасан, кг/	10 000	10 000	100.0
3 СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
Сүү /задгай, л/	900	1 200	133.3
Сүү / савласан, л/	2 600	2 700	103.8
Тараг /задгай, л/	1 200	1 400	116.7
Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	13 000	15 000	115.4
Айраг /л/	3 500	3 500	100.0
Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	4 500	100.0
Өндөг /ш/	350	350	100.0
4 БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС			

	Ургамлын тос /л/	3 800	3 800	100.0
	Өөхөн тос /кг/	2 000	2 000	100.0
	Шар тос /кг/	13 000	13 000	100.0
	Масло /задгай, кг/	4 500	4 500	100.0
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	800	1 000	125.0
	Лууван /кг/	1000	1 200	120.0
	Манжин /кг/	1000	1500	150.0
	Байцаа /кг/	1000	1200	120.0
	Сонгино /кг/	1200	1800	150.0
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3 500	4 200	120.0
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2 300	3 000	130.4
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1 645	1 750	106.4
	Бензин А - 92	1 795	1 840	102.5
	Дизелийн түлш	2 105	2 470	117.3

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Нотариатын тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар аймаг дахь Нотариатын танхимтай хамтран нийт нотариатын үүрэг гүйцэтгэгч нарт сургалт зохион байгууллаа.

2019 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн 3133 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1125 буюу 35,9 хувийг гэмт хэргийн шинжтэй, 2008 буюу 64,1 хувийг зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл тус тус эзэлж байна.

Гэмт хэргийн шинжтэй 1125 гомдол, мэдээллийн 840 мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 5 гомдлыг харъяаллын дагуу шилжүүлж, 277 гомдолд хэрэг нээхээс татгалзсан саналыг прокурорт гаргаж, нийт бүртгэсэн гомдол мэдээллийн 1117 буюу 99,2 хувийг хуулийн хугацаанд нь шалган шийдвэрлэж, ажиллагаанд 3 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй байна.

Зөрчлийн шинжтэй 2008 гомдол, мэдээллийн 921 гомдол мэдээллийг зөрчлийн хэрэг нээсэн болон хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн, 12 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 1057-д нь зөрчлийн шинжгүй татгалзах саналтай прокурорт хүргүүлж, 17 гомдлыг харъяаллын дагуу шилжүүлж, нийт бүртгэсэн гомдол, мэдээллийн 1993 буюу 99,2 хувийг хуулийн хугацаанд шалган шийдвэрлэж, ажиллагаанд 1 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй байна. Нийт хүлээн авч бүртгэгдсэн 3133 гомдол, мэдээллийн 3110 буюу 99,2 хувийг хуулийн анхны хугацаанд шалгаж шийдвэрлэжээ.

Аймгийн хэмжээнд 2019 оны эхний 11 сард 527 холбогдогчтой 2121.6 сая төгрөгийн хохиролтой, 720 гэмт хэрэг бүртгэгдэж урьд оны мөн үеэс 4 хэргээр буюу 0.5 хувиар буурчээ. Гэмт хэргийн илрүүлэлт 54,5 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.6 хувиар өссөн байна.

Хэрэг бүртгэлтийн 556 хэрэг бүртгэгдсэнээс эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар 303 хэрэг татаж, гэмт хэргийн илрүүлэлт 54,5 хувьтай байна.

Улсын бүртгэлийн хэлтсээс 1 дүгээр сард газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ 197, лавлагаа 1 олгож үйлчиллээ.

Иргэний бүртгэлийн чиглэлээр 1 дүгээр сард төрсний бүртгэл 172, гэрлэлтийн бүртгэл 35, гэрлэлт цуцалсны бүртгэл 10, үрчлэлт 4, эцэг тогтоолт 6, овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл 4, нас баралт 42, нийт олгосон иргэний үнэмлэх 366, шинээр олгосон иргэний үнэмлэх 107, дахин олгосон иргэний үнэмлэх 74, иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан 185, гадаад паспорт олголт 144, ОХУ-ын хавсралт 2165, аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 254, хот доторх шилжилт хөдөлгөөн 311 тус тус бүртгэгдсэн байна.

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Хүдэр сумын ЗДТГ, Барилга угсралтын контор, аймгийн Банкны контор, Сүхбаатар сумын 1 дүгээр сургуулийн нийт 4 хөмрөгийн 83 хн-ний 10523 хуудас баримтын агуулгыг уншиж заалт 8345, хүний нэр 35344, газарзүй нэр 3783, байгууллагын нэр 3857-г шивж эх баримттай холбох ажлыг хийж гүйцэтгэсэн. Сүхбаатар сумын 1 дүгээр сургуулийн хөмрөгийн 39 хадгаламжийн нэгжний 5437 хуудас баримтыг сканердаж мастер хувь үүсгэсэн. Мөн сканердсан баримтыг DVD дээр хуулж нөөц хувь үүсгэсэн.

Иргэд, албан байгууллагын хүсэлтийн дагуу архивын хуулбарцахимаар-537цаасансуурьтайбаримтнаас-65, мастерхувиас-186, цалингийн тодорхойлолт-2, эхийн одонгийн лавлагаа-1, магадлагаа, тодорхойлолт-117-г тус тус гаргаж үйлчилсэн байна.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр

Ерөнхий боловсролын сургуулийн сайжруулсан сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх, суралцагчдын мэдлэг, чадварыг үнэлэх үнэлгээний блюпринт, даалгавар боловсруулах, шинжлэх, даалгаврын хүнд, хөнгөний зэрэг, ялгах чадварыг тодорхойлдог чадвартай болгох, элсэлтийн ерөнхий шалгалтад амжилттай бэлтгүүлэх зорилгоор 12 дугаар ангид монгол хэл бичиг, уран зохиол, математик, нийгмийн ухаан, гадаад хэл, хими, физикийн хичээл зааж байгаа багш нарын болон 5 дугаар ангийн багш нарын сургалтыг Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1, 2 дугаар сургууль дээр зохион байгуулж сургалтад 35 сургуулийн 300 гаруй багшийг оролцуулж, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэн ажиллалаа.

Томуу, томуу төст өвчний дэгдэлт ихэсч, хүүхдүүдийн өвчлөл нэмэгдэж байгаа учраас 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн ирцийн мэдээллийг авч, өвчлөлийн хувийг тооцож, аймгийн Засаг даргын Тамгын газарт мэдээллийг хүргүүлж ажилласан ба өвчлөл нэмэгдсэн учраас өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэгүүдийн үйл ажиллагааг 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийг дуустал, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааг 2019 оны 12 дугаар сарын 25-27-ны өдрийг дуустал хугацаанд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 12 дугаар сарын 25-ны А/839 тоот “Хичээл, сургалтын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох тухай” тушаалаар зогсоосон. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 01 дүгээр сарын 07-ны А/05 тоот “Зохицуулалт хийх зөвшөөрөл олгох тухай” тушаалаар сурагчдын улирлын амралтын хугацаа сунгасантай холбогдуулан хичээлийн жилийн үргэлжлэх хугацаанд өөрчлөлт оруулахгүй бөгөөд хичээлийн жилийн үргэлжлэх хугацаанд сургалтын хөтөлбөр бүрэн хэрэгжсэн байх зохион байгуулалтыг авч ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газарт үүрэг болгосны дагуу 2019 оны 12 дугаар сарын 25-27-ны өдрийн, 2020 оны 01 дүгээр сарын 13-17-ны өдрийн нийт 8 хоногийн хичээлийг сурагчдад хүндрэл бэрхшээл учруулахгүйгээр агуулгаар нь нөхөж хичээллүүлэхийг чиглэл болгож, сургуулиудад албан бичиг хүргүүлж ажилласан.

“Орон зайнаас үл хамааран суралцъя, ажиллая” төслийн танилцуулгыг хийж, бага боловсролын сургалтын менежерүүдийг чадавхижуулах сургалтыг зохион байгууллаа.

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, удирдах ажилтнуудын дунд боловсролд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх, багшийн мэргэжил, арга зүйн болон судалгаа шинжилгээний чадварыг дэмжих, сургалтын дэвшилтэт технологийн үзэл санаа, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Оны шилдэг илтгэл шалгаруулах эрдэм шинжилгээний бага хурал”-ыг 2019-2020 оны хичээлийн жилд “Суралцагчдын ялгаатай байдлыг сургалтад харгалзах нь-үйл ажиллагаа, үр дүн” сэдвээр зохион байгуулж, шилдэг

илтгэл шалгаруулах эрдэм шинжилгээний бага хуралд 5 бүсээс шалгарсан багш нарын багийн төлөөлөл оролцсоноос Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн багш нарын багийн “Ашигтай арван хуруу программаар сурагчдын ялгаатай байдлыг дэмжих нь” илтгэл шалгарч, улсын “Оны шилдэг илтгэл шалгаруулах эрдэм шинжилгээний бага хурал”-д аймгаа төлөөлөн оролцох эрх авсан.

Суралцагчдын амралт болон хорио тогтоосон үед багш нарын эрэлт хэрэгцээнд үндэслэсэн захиалгат сургалтуудыг Баянгол, Мандал сумын 1, Сүхбаатар сумын 1 дүгээр сургуульд зохион байгуулж, Мандал 2,4 дүгээр сургуулийн багш нарт Монгол хэлний сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлаар зөвлөгөө өгч ажиллалаа. Бага ангийн нийт 80 багш хамрагдсан.

Сургуулиудтай онлайнаар холбогдох хуваарийг гаргаж, 3 удаагийн онлайн сургалтыг зохион байгуулж, бага ангийн сургалтын менежерүүд бага ангийн багш нартай холбогдож цаг үеийн мэдээлэл болон сайжруулсан хөтөлбөрийн дагуу төлөвлөгөө хийх аргачлалыг танилцуулсан.

2.Эрүүл мэндийн чиглэлээр

Мандал сумын Нэгдсэн эмнэлэгт 2019 оны 4-р улиралд эндсэн нярайн эндэгдэлд магадлан хэлэлцэх хурлыг зохион байгуулж “Хүүхдийн эндэгдлийг магадлан хэлэлцэх зөвлөл”, Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн удирдлага, чанарын албаны дарга, эх барих эмэгтэйчүүдийн эмч, хүүхдийн эмч, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, холбогдох эмч нарын төлөөлөл 28 хүн оролцсон. Хурлаар нярайн эндэгдлийн шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлийг тодорхойлж цаашид нярайн эндэгдлээс сэргийлэх чиглэлээр анхаарах асуудлыг тодорхойлж зөвлөмж гарган ажилласан.

Эрүүл мэндийн яамнаас дэвшүүлсэн “Эрүүл мэнд 8/20” зорилт, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/327 тоот тушаал “Тэмбүүг устгая” үйл ажиллагааны төлөвлөгөө, аймгийн Засаг даргын “2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдаж байгаа халдварт болон халдварт бус өвчнийг эрт илрүүлэх цогц үзлэг оношилгооны 2 дах шатны үзлэгийг Сайхан сумын иргэдийн дунд зохион байгуулж 2260 иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хүргэж “Мэдээллийн цахим сан”-д баяжилт хийсэн.

Лабораторийн шинжилгээнд 1166 хүн, цээжний хөндийн эмгэг илрүүлэх оношилгоонд 1228 хүнийг хамруулсан.

3.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар

2019 оны 12-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй 640 байсан бол 111 иргэн шинээр бүртгүүлж, ажил олгогчоос ирүүлсэн 48 ажлын байранд 24 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 102 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 625 болсон байна.

Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй нийт 30427 хүүхдэд хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Халамжийн сан: Тайлант хугацаанд халамжийн санд улсын төсвөөс 15,162,612,5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 262175,0 мянган төгрөг нийт 15,419,987,5 мянган төгрөгийн төсөв батлагдсан.

Орон нутгийн төсвийн орлогоос: 2020 оны 1 сарын байдлаар 2 иргэнд 2400,0 мянган төгрөгийг онцгой тохиолдлын тэтгэмжинд 2 иргэнд олгосон.

Улсын төсвийн орлогоос: Халамжийн санд улсын төсвөөс тайлант хугацаанд 6124 иргэнд 659183.9 мянган төгрөгийг олгоод байна. Үүнд:

-Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2181 иргэнд 377170.3 мянган төгрөг

-Нийгмийн халамжийн тэтгэмжид 1476 иргэнд 117714,3 мянган төгрөг

-Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжид 1388 иргэнд 117088,4 мянган төгрөг

-Жирэмсэн эхийн тэтгэмжид 826 эхэд 29555,8 мянган төгрөг

-Ахмадын настанд олгох хөнгөлөлт, тусламжинд 37 ахмадын 5351,6 мянган төгрөг

-Алдар цолтон ахмад настанд 59 ахмадын 9870,0 мянган төгрөг

-Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламжинд 159 иргэний 3633,6 мянган төгрөг

-Хүнсний эрхийн бичгийн 2072 иргэнд 24840,0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.

4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар

“Хүүхдийн тусламжийн 108 төвөөс шилжин ирсэн 7 дуудлагыг хяналтандаа авч, хамтарсан баг хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлсэн. Дуудлагыг хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрээр нь ангилбал бие махбодын хүчирхийлэл 1, сэтгэл санааны 3, үл хайхрах хүчирхийлэл 3 байна.

Хүүхдийн эрхийн тухай хуулийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийх ажлын хэсэг 5 хоног аймагт ажиллаж, судалгааны ажлын хүрээнд аймгийн удирдлагууд, Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газар, Сайхан сум, Сүхбаатар сумын 3 дугаар баг, Өмгөөлөгч, Шүүх, Прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар зэрэг хуулийн хэрэгжилтэд хамаарах ажилтан, албан хаагчидтай уулзаж фокус болон ганцаарчилсан ярилцлага хийж, үнэлгээний ажлыг зохион байгууллаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хуралд хуваарийн дагуу 2 удаа оролцож, хөгжлийн бэрхшээлтэй 32 хүүхдийн байнгын асаргааг тогтоосон. Өсвөрийн шатарчдын “Цодгор хүү” аймгийн уралдааныг зохион байгуулж нийт 4 насны ангиллаар 120 хүүхэд оролцож оюун ухаан, ур чадвараа сорьсноос шалгарсан 1 хүүхдийг “Цодгор хүү -2020” улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхээр шагналаа.

5.Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар:

Нийгмийн даатгалын хэлтэс нь 2020 оны 01 дүгээр сарын байдлаар 39,5 тэр бум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөтөйгээс 01 дүгээр сарын 25-ны байдлаар өссөн дүнгээр 42,8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж 108,12 хувийн биелэлттэй ажиллаж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 16991 тэтгэвэр авагчдад 70822874,72 мянган төгрөгийг тэтгэвэрт, Тэтгэмжийн даатгалын сангаас 7642 хүнд 3261213,5 мянган төгрөгийг хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрлэлийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 287 хүнд 1165079,05 мянган төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 568 хүнд 905978,41 мянган төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид тус тус олгожээ.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоор 2020 оны 01 сард нийт 3 хурал хийж 278 хүнээс, 18 хүнийг цуцалж, 53 хүн шинээр тогтоолгосон, 207 хүн актаа сунгуулсан байна. Архивын лавлагааг 2020 оны 01 дүгээр сарын 21-ний байдлаар 104 лавлагааг гаргаж иргэд, даатгуулагчдад түргэн шуурхай үйлчилсэн.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын “Зөвлөн туслах” ажлын хэсгийн удирдамжийн дагуу 01-р сарын 14 нөөс 15 нд Алтанбулаг, Шаамар суманд 1-р сарын 20-23-нд Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн суманд тус тус ажиллалаа.

Улсын аварга тариаланч хамт олон, Улсын аварга тариаланч, Улсын аварга ногоочин-оор шалгаруулах аж ахуйн нэгж байгууллагуудын материалыг хүлээн авч Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн. Мөн Улсын аварга малчнаар тодруулахаар 9 сумаас 12 малчны тодорхойлолт ирснийг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан Улсын аварга малчин

өрх шалгаруулах журмын дагуу урьдчилсан шалгаруулалт хийж Зүүнбүрэн, Цагааннуур, Баянгол, Жавхлант сумдын материалыг ХХААХҮЯ-нд хүргүүлээ.

Мандал сумын “Спирт бал бурам” ХХК-ий 3610 тонн спиртын захиалгыг авч ХХААХҮЯ-нд, зээлийн батлан даалтын тайланг гаргаж, 1 дүгээр сарын 5-нд Зээлийн батлан даалтын хороонд хүргүүлсэн.

2019 оны жилийн эцсийн мал тооллогын нэгдсэн дүнгээр аймгийн нийт малын тоо 1682450 толгойд хүрч өнгөрөгч оноос 142414 толгой буюу 8,4%-иар өслөө. Нийт мал сүргийг өсөлтийг төрлөөр нь авч үзвэл Тэмээ 11 толгойгоор өсч 483, адуу 5806 толгойгоор өсч 103410, үхэр 15471 толгойгоор өсч 232276, хонь 38840 толгойгоор өсч 744714, ямаа 85908 толгойгоор өсч 601578 толгой мал тус тус тоологдсон. нийт сүргийн бүтцээр нь авч үзвэл 46,8% буюу 788835 толгой нь хээлтэгч мал, 0,7% хээлтүүлэгч мал, 36,5% төл мал, 15,8%-ийг эр сувай мал эзэлж байна. Нийт мал сүрэгт эзлэх цэвэр эрлийз малын тоо толгой 1192 толгойгоор буурч 392975 толгой тоологдсон нь өнгөрсөн оноос 0,3%-иар буурч нийт сүргийн 23,3 хувийг эзэлж байна.

Үндэсний үйлдвэрт арьс шир тушаасан иргэдийн урамшуулалд хамрагдахаар ирүүлсэн материалыг нэгтгэж мэдээллийг программд шивж орууллаа. “Мерси кор” ОУБ-ын даван туулах, дасан зохицох чадвартай орон нутгийн иргэд төслийн хүрээнд зарлагдсан төслийн танилцуулга уулзалтанд оролцож түншлэгч талуудад хамтын ажиллагааны хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг мэдээлэх ажлыг зохион байгууллаа.

Ажилласан сумдад мал өвөлжилтийн нөхцөл байдал хэвийн сумдад цас багатай мал сүрэг тарга хүч алдаагүй өвөлжилт хэвийн, цаашид цас нэмт орохгүй бол мал төллөх цагаар малын амны усны асуудал хүндэрч бэлчээр муудаж болзошгүй байдал ажиглагдлаа.

Аймгийн хэмжээнд 2020 оны 01 дүгээр сарын байдлаар Цагааннуур, Алтанбулаг, Зүүнбүрэн сумдад шөвөг яр өвчнөөр нийт 7 толгой хурга, ишиг өвчилсөн тохиолдол бүртгэгдсэн ба сумын МЭҮН-ийн малын эмч нар дуудлагын дагуу үзлэг, оношлогоог хийж шаардлагатай эмчилгээг хийснээр бүгд эдгэрсэн мэдээтэй байна.

Мал эмнэлгийн нэгдсэн системийг 01 дүгээр сарын 01-ээс нэвтрүүлж 15 сумаас 1208 иргэнд цахим гэрчилгээгээр адуу 184, үхэр 668, тэмээ 6, хонь 1519, ямаа 1201 бүгд 3578 толгой мал амьтан, адууны мах 18691, үхрийн мах 13468, тэмээний мах 460, хонины мах 43710, ямааны мах 29659, гахайн мах 942 бүгд 223930 кг, дайвар мах 660 кг, адууны шир 197, үхрийн шир 826, тэмээний шир 1116 хонины нэхий 1141, ямааны арьс 2736, сүү 1351,4, ааруул 151, өрөм 61 кг тус тус цахим гэрчилгээ олгож баталгаажууллаа.

Төв аймгийн Батсүмбэр сум, Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 21-р хороо, Өвөрхангай аймгийн Бүрд, Хархорин сум, Баянхонгор аймгийн Гурван булаг зэрэг аймаг сумдаас адуу 159, үхэр 184, хонь 2225, ямаа 870 нийт 3438 толгой мал шилжин ирсэнээс отроор 3425, арилжаагаар 13 үхэр тус тус шилжин ирсэн, Сүхбаатар аймгийн Халзан, Дархан уул аймгийн Хонгор, Төв аймгийн Сэргэлэн болон аймгийн сумд дотроо 40 толгой мал арилжаагаар шилжин явсан дүнтэй байна.

Малын халдварт өвчингүй эрүүл, тайван статустай бүс болсонтой холбогдуулан шилжилт хөдлөгөөний хяналтыг тавьж байгаа бөгөөд энэ сард Төв аймгаас шилжин ирсэн 780 толгой богийг тухайн орон нутагт буцаасан.

Зургаа. Хөрөнгө оруулалт, газрын харилцаа, барилга хот байгуулалтын чиглэлээр:

Аймгийн хэмжээнд төр төсвийн байгууллагуудын илүүдэлтэй буюу ашиглагдахгүй үндсэн хөрөнгө болох барилга байгууламжийн 72 объектыг банк санхүүгийн байгууллага буюу иргэдтэй гэрээ хийн баталгаажуулан ажилласан. Сумд, Засаг даргын харьяа агентлагуудын 2020 оны бараа, ажил, үйлчилгээ

худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Цахим худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn/-д оруулахад хяналт тавьж ажиллаж байна.

Захиалагчаас 28 төсөл арга хэмжээ зарлуулах хүсэлт өгсөнөөс 16 ажлын ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг ирүүлсэн. Үүнээс цахим системд 16 ажлыг зарласан бөгөөд 5 ажлын үнэлгээний шатандаа, 5 ажлын гэрээ байгуулах эрх олгосон, 12 ажлын техникийн тодорхойлолт ирээгүй байна.

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөгдөж байгаа дараах зураг төсвийг хянаж баталгаажуулсан. Үүнд:

-Алтанбулаг суманд шинээр баригдах 3.6км автозамын техникийн зураг төсөл

-Баянгол сумын ЗДТГ-ын өргөтгөлийн скиз зураг.

-Хөрс авто сервис ХХК-ий ШТС –ийн барилга /Сүхбаатар сум/

Мөн Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөгдөж байгаа төсөл арга хэмжээнд архитектур төлөвлөлтийн даалгавар гаргаж өгөөд байна. Үүнд:

-Хүдэр сум 10 ортой эмнэлэгийн барилга.

-Хөрс ХХК -ний ШТС /Сүхбаатар сум/

Сүхбаатар сумын нийгмийн дэд бүтцийн барилга болон орон сууцны барилгуудын мэдээллийг Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд “Arc Gis 10,5” программд иргэн, аж ахуй нэгжээс авсан мэдээллийг зохих объектод нь шивж оруулсан. 1-р сард нийтдээ 81 барилгыг бүртгэж, Сүхбаатар суманд 6-р сургуульд өргөтгөлөөр баригдаж байгаа Ариун цэврийн байгууламжийн барилгад үзлэг хийлээ.

Газрын тухай хуулийн дагуу газрын нэгдмэл сангийн 2019 оны тайлан, 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжсэн түвшин, түүний тоон зураг, 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө, Засгийн газрын 119 дүгээр тогтоолын хэрэгжилт, 2020 оны саналыг сумдаас авч нэгтгэн 2020 оны 01 дүгээр сарын 05-ны дотор ГЗБГЗЗГазарт хуулийн хугацаанд хүргүүлж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2019-ны А/476 тоот захирамжаар Сүхбаатар сумын 18-аас дээш насны 4 иргэнд шинээр 2637м² буюу 9221250 төгрөг, 2019.12.30-ны өдрийн А/475 тоот захирамжаар Сүхбаатар сумын 0-18 насны 8 иргэнд шинээр 7691м² буюу 22265000 төгрөгийн үнэ бүхий газрыг тус тус гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэ төлбөргүйгээр өмчлүүлээ.

Тайлант хугацаанд Сүхбаатар суманд газар өмчилж авсан 5, Алтанбулаг суманд газар өмчилж авсан 12 иргэнд тус тус газар өмчлөлтэй холбоотой баримт бичгийг бүрдүүлэн өгч Улсын бүртгэлийн хэлтэст шилжүүлж ажиллалаа.

Сумдын 2020 оны газар зохион байгуулалтын батлагдсан төлөвлөгөөг газрын кадастрын мэдээллийн сангийн б хувилбарт буюу <http://192.168.15.216/home-d> оруулсан.

Сүхбаатар сумын инженерийн шугам сүлжээ бүхий газарт эрх баталгаажуулах 5 иргэн, газар эзэмших эрхээ бусдад шилжүүлэх 28 иргэн, эрхийн гэрчилгээний хугацаа сунгуулах хүсэлт гарсан 8 иргэн, эзэмшил газраа хэсэгчилэн шилжүүлэх хүсэлт гаргасан 3, газар эзэмших эрхийн Э дугаар авах хүсэлт гаргасан 28 иргэний өргөдөл хүсэлтийг хүлээн авч, аймгийн Засаг даргын 9 удаагийн захирамжаар 21 иргэний азар эзэмших эрхийг шилжүүлж, 6 иргэний газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгаж, 6 иргэний газар эзэмших эрхийг баталгаажуулж хуулийн хугацаанд өргөдөл хүсэлтийг тус тус шийдвэрлэв.

Мөн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д зааснаар 25 иргэн, 3 аж ахуйн нэгжийн 29 нэгж талбарын газар эзэмших эрхийн гэрчилгээнд Э дугаар авах хүсэлтийг дундын мэдээллийн сангаар дамжуулан Улсын бүртгэлийн хэлтэст илгээв. Тус сард 23 иргэн, 1 аж ахуйн нэгжийн нийт 25 газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулан газар эзэмшигчийн улсын бүртгэлд бүртгэж баталгаажуулав.

Долоо. Байгаль орчны чиглэлээр

1-р сарын 2-ноос 4-ний хооронд хүйтний эрч эрс чангарч шөнөдөө 33-38 градус, өдөртөө 17-22 градус хүйтэн байхыг анхааруулан ажиллаж байна.

2020 оны 2 дугаар сарын 3-ны 20 цагаас 2020 оны 2 дугаар сарын 4-ний 20 цаг хүртэлх цаг агаарын урьдчилсан мэдээгээр:

Сэлэнгэ аймгийн нутгаар Багавтар үүлтэй. Цас орохгүй. Салхи баруун хойноос секундэд 3-8 метр. Шөнөдөө Орхон, Сэлэнгэ, Ерөө голын сав газраар 32-37 градус, өдөртөө 16-21 градус, бусад сумдын нутгаар шөнөдөө 27-32 градус, өдөртөө 13-18 градус хүйтэн байна.

Сүхбаатар хот орчмоор Багавтар үүлтэй. Цас орохгүй. Салхи зүүн өмнөөс секундэд 4-9 метр. Шөнөдөө 28-30 градус, өдөртөө 16-18 градус хүйтэн байна.

2020 оны 2 дугаар сарын 5-наас 2020 оны 2 дугаар сарын 9-нийг хүртэлх 5 хоногийн цаг агаарын урьдчилсан мэдээгээр энэ хугацаанд цас орохгүй, салхи баруун хойноос секундэд 4-9 метр, шөнөдөө 23-28 градус, өдөртөө 8-13 градус хүйтэн байна.

Найм.Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Алтанбулаг сум:

Сумын шинэ жилийн баярын арга хэмжээг зохион байгуулж шилдэг аж ахуйн нэгж, багш, сурагч, тариаланч, ногоочин, ажилчин, малчин, өрхийн үйлдвэрлэл эрхлэгч, соёлч өрхүүдийг шалгаруулан шагнаж урамшуулсан.

“Орон нутгийн тогтвортой хөгжил ба хамтын оролцоотой шийдвэр гаргах нь” сургалтыг Ой бүхий аймгуудын биологийн олон янз байдлын хамгаалал, тогтвортой ойн менежмент, нүүрстөрөгчийн хуримтлалыг нэмэгдүүлэх нь” төслийн санхүүжилтээр хийж, мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөлт, төрийн болон төрийн бус байгуулагын албан хаагчдыг хамруулсан.

Тус аймгийн 1-р цэцэрлэгт 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 2 бүлгийн өргөтгөлийн барилгыг хүлээн авч, нүүлгэлт, тохижилтын ажлыг хийлээ.

Аймгийн хэмжээнд хөл хорио тогтоосон хугацаанд багш ажилтны мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээнүүдийг зохион байгуулж, ёс зүйн болон сургалтын арга хэрэглэгдэхүүн, туслах багшийн эрх үүрэг, эрүүл ахуйн дадал зэрэг чиглэлээр сургалт явуулсан.

Баруунбүрэн сум:

Монгол Улсад анхны ардчилсан “Үндсэн хууль” батлагдан мөрдөгдөж эхэлсэний 28 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгууллаа. Энэ ажлын хүрээнд иргэдэд хууль сурталчлах ажлыг зохион байгуулж, сумын ард иргэд, оюутан залуучуудын дунд гарбөмбөгийн тэмцээн, “Монгол Улсын Үндсэн хуулийг хэн сайн мэдэх вэ” АХА тэмцээнийг зохион явууллаа. “Үндсэн хууль”-ийг сурталчлах, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаар мэдээлэл хийж, гарын авлага материалыг нийт 50 ширхэгийг тараасан. Сургалтанд төр төсвийн байгууллагын ажилтан албан хаагч, оюутан залуус, иргэд гэсэн нийт 90 гаруй иргэн оролцлоо.

Тайлант сард сумын үйлдвэр, аж ахуй нэгжийн судалгаа, аймгийн аварга малчнаар Дорждангийн Гансүх, Алтан унаганы эзнээр Ламзавын Амгалан, аймгийн аварга тариаланч хамт олноор “Бүрэн оргил од” ХХК-ийг, аварга ногоочноор Намжилдоржийн Бундтулга нарыг шагнуулахаар, 2020 онд шаардагдах үр, хор, бордоо, гербицидийн захиалгыг аж ахуйн нэгж, иргэдээс гарган аймгийн ХХААГ-т тус тус хүргүүлсэн. “Нэг суурин, нэг бахархал” аян Сэлэнгийн бренд хөтөлбөрийн хүрээнд аймгийн бренд бүтээгдэхүүний каталог, ном товхимол хэвлүүлэх болсонтой холбогдуулан сумын хэмжээний 4 төрлийн бренд бүтээгдэхүүний танилцуулгыг зургийн хамт мөн хүргүүлж ажиллалаа.

Тус суманд мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлж байгаа 2 нэгж цахим бүртгэлийн программыг татан авч 2020 оны 01 сарын 01-ээс эхлэн бүртгэлийн системд гарал

үүслийн гэрчилгээг бичиж мал эмнэлгийн тасгаар хянуулж батлуулан ажиллаж байна. Мал, мах худалдан борлуулж буй малчидад шинээр батлагдсан мал амьтны эрүүл мэндийн тухай хуульд заагдсаны дагуу эмийг малчин дур мэдэн хэрэглэхгүй зөвхөн хариуцсан малын эмчээр хийлгэж байх талаар анхааруулга мэдээлэл өгч ажилласан.

Газрын төлбөр, татварын программыг 2020 оны 01 дүгээр сараас улсын хэмжээнд нэвтрүүлэхтэй холбоотойгоор газрын кадастрын мэдээллийн сангийн мэдээллийг нягтлах, шалгах, нөхөн оруулах, засварлах, төлбөр ноогдуулах ажлыг гүйцэтгэж, 2020 оны сумын Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд иргэн аж ахуйн нэгжид эзэмшүүлж, өмчлүүлэхээр тусгагдсан газруудыг газрын кадастрын цахим систем web-д оруулж, ЛМ-д холбогдоогүй байсан 64 нэгж талбарыг холбосон байна.

Тус сумын Эрүүл мэндийн төвд 01 дүгээр сард амбулаторийн үзлэг 161, урьдчилан сэргийлэх үзлэг 84, осол гэмтлийн өвчлөл 2, эмнэлэгт хэвтсэн 28, шинжилгээнд хамрагдсан 177 байна. Жирэмсний хяналтанд байгаа 31, шинээр жирэмсний хяналтанд орсон 5 байна. Сумын эмнэлэгт төрсөн эх-1 эх, хүүхдийн биеийн байдал сайн сумын эмчийн хяналтанд долоо хоног бүр эргэлт хийж зөвлөгөө өгч байна.

Сурагчдын 2 дугаар улирлын амралт 2019 оны 12-р сарын 24-ний өдрөөс эхлэн 2020 оны 01 дүгээр 20-ныг хүртэлх сурагчдын амралтын хугацаанд бага дунд ангийн сургалтын менежерүүд цагийн хуваарь гарган багш нарын дүнгийн анализ гарган хичээл бүрээр цахим журналыг талаар цаашид анхаарах асуудлын талаар багш нарт зөвлөгөө өгч, багш нарыг хуваарийн дагуу чадавхжуулах арга зүйн сургалтанд хамруулан ажиллалаа.

Эрүүл мэндийн төвтэй хамтран Томуу томуу төстэй өвчин, Зөв хооллолт зэрэг сэдвийн хүрээнд 38 багш ажилтанг хамруулан тус сургалтуудыг зохион явуулсан. Мөн гамшгийн эрсдлийг бууруулах зорилгоор зарлан мэдээллийн дохион дуугаар анги хамт олон хэрхэн өөрийгөө болон бусдыг хэрхэн хамгааллах талаар дадлага сургуулилтыг зохион байгуулж, нийт 551 суралцагч багш нар хамрагдлаа.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагаас энэ сард улсын хэмжээнд 2019 оны 12-р сарын 25-наас 2020 оны 1-р сарын 17-ныг дуустал томуу томуу төст өвчний дэгдэлт их байгаагийн улмаас ЕБСургууль, Цэцэрлэгийн үйл ажиллагаанд хорио тогтоосон. Энэ хугацаанд багш, туслах багш нар ороогүй хичээлийг цаашид нөхөх учир хичээлийн сэдвийг сараар төлөвлөж “Ажил мэргэжил” сэдвийн хүрээнд зориуд зохион байгуулах хичээл үйл ажиллагаандаа хэрэглэгдэх үзүүлэн тарааж өгөх материал зэргийг бэлтгэн хийж ашиглахад бэлэн болгож ажиллалаа. Эцэг эхчүүдэд ханиад томуунаас урьдчилан сэргийлэх гарын авлага, хүүхдийг дулаан хувцаслаж дааруулахгүй байх заавар зөвлөгөө, томуу томуу төст өвчний тархалт болон хэрхэн урьдчилан сэргийлэх талаар заавар зөвлөгөөг цахим хуудас бүлгүүдийн фэйсбүүк хуудасаар дамжуулан өгч ажиллаж байна.

Ерөө сум:

“Үндсэн хууль” батлагдсаны өдрийг тохиолдуулан иргэд, төр төсвийн байгууллагын албан хаагчид, ахмадуудын дунд “Үндсэн хууль” болон үндсэн хуульд шинээр орсон нэмэлт өөрчлөлт”-үүдийн талаар мөн түүх нийгмийн хөгжөөнт асуултуудаас бүрдсэн “АХА” танин мэдэхүйн хөгжөөнт тэмцээнийг 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулан явууллаа. Уг арга хэмжээнд 50 гаруй иргэн оролцсон.

Сумын Засаг даргын Тамгын газраас “Үдэж цэгцэлье-7” хоногийн арга хэмжээг зохион байгуулж, өмнөх оны баримтуудыг үдэж цэгцэллээ. Мөн сумын ЗДТГ-ын ажилтан албан хаагчдын “Сонсгол мэдээллийн цаг”-аар мэдээлэл тавих хуваарийг гарган батлуулж, эхлүүлсэн бөгөөд энэ сард Татварын улсын байцаагчаас “Татварын удирдлагын нэгдсэн систем”, шинэчлэн батлагдсан “Хувь хүний орлогын албан татвар”-ын тухай хуулийн талаар мэдээлэл өгч нийт 24 албан хаагч хамрагдлаа.

Малчдын өвөлжилтийн байдалтай танилцах ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд 2020 оны 01-р сарын 23-ны өдөр Тавин багийн малчидтай уулзаж, санал хүсэлтийг нь сонсох, эмнэлэгийн үйлчилгээг хүргэх, 2019 онд хийж хэрэгжүүлсэн онцлох ажлуудын талаар мэдээллийг хүргэлээ. Энэ жилийн хувьд цаг агаар харьцангуй дулаан, малчдын өвөлжилт сайхан, малын тэжээлийн нөөц хангалттай байлаа.

Өвөлжилтийн байдалтай холбогдуулан сумын ЗТДГ-аас суманд үйл ажиллагаа явуулж буй модны рам ажиллуулж буй иргэдэд санал тавьсанаар нийт 10 өрхөд 11 портер уурган зах, зах банзыг буулгаж дэмжлэг үзүүллээ.

2020 онд тариалах талбайн урьдчилсан дүнг гаргасан. Энэ онд 14 аж ахуй нэгж, 8 иргэн 15000 га талбайд үр тариа, тос, тэжээлийн ургамал тариалж 9000га талбайд уринш бэлтгэхээр болоод байна. 2019 оны арьс, ширний падааныг 1,2-р багийн 69 малчин өрхөөс бүртгэл үүсгэн авч програмд шивж оруулсан.

2019 оны жилийн эцсийн мал тооллогоор Ерөө сумын хэмжээнд 80598 толгой мал тоологдож, малчин өрх 275, мал бүхий өрх 389, нийт малчин мал бүхий иргэд 664 тоологдлоо.

“Цэргийн шинэчилсэн тоо бүртгэл”-ийг зохион байгуулсан. “Хүн ам орон сууц-2020” улсын ээлжит тооллогыг 2020 оны 01 дүгээр сарын 09-ны өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 15-ны хооронд болж өнгөрлөө. Сумын хэмжээнд нийт 195 өрх хамрагдсан бөгөөд уг ажлыг хуулийн хугацаанд 3 баг дээр явуулж тооллогын дүнг аймгийн Статистикийн хэлтэст хүргүүллээ.

2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлахтай холбогдуулан 01 дүгээр сарын 08-ны өдөр 2-р багийн ИНХ-ыг 115 өрхийн төлөөлөл буюу 75%-ийн ирцтэйгээр хуралдаж өмчлөлийн, өвөлжөөний, худалдаа үйлчилгээний, газар тариалангийн, үйлдвэрлэлийн, төмс, хүнсний ногооны зэрэг зориулалтаар 48 иргэний өргөдөл хүсэлтийг хэлэлцэн иргэдээс гарсан саналыг төлөвлөгөөнд тусгахаар ИТХ-д хүргүүлсэн.

Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 1-р сарын 5-ны өдөр иргэд, төр төсвийн байгууллагын албан хаагчдын дунд “Хан голомт” хувьцаат компаний захирал н.Азбаяр “Хувь хүний хөгжил” сэдвээр лекц хийлээ. Уг сургалтанд 50 гаруй иргэд хамрагдсан. Мөн 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр “Жинхэнэ эр хүн” сэдэвт сургалтыг аавуудын дунд зохион байгуулж нийт 36 аавыг, 01 дүгээр сарын 22-ны өдөр “Хүмүүжлийн эерэг арга” сэдэвт 2 өдрийн сургалтыг хийж, 35 хүн хамрагдлаа.

Азийн хөгжлийн банк, ХХААҮЯ-тай хамтарсан “Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амжиргааг сайжруулах” сургалт 2020 оны 01 дүгээр сарын 23, 24-ний өдрүүдэд болж 40 хүн хамрагдлаа.

ЕБС-ийн багш, ажилчид нийт 10 удаагийн сургалтанд 74 багш хамрагдсан. Үүнээс төвлөрсөн 3 сургалтанд 3 багш, орон нутгийн 7 сургалтанд 16 багш, ажлын байран дээрх 3 сургалтанд 55 багш хамрагдсан.

Суралцагчдын танин мэдэхүйн хүрээг тэлэх, амжилт гаргасан багш, суралцагчдыг алдаршуулах зорилгоор Сэлэнгэ аймгийн 7 бахархал, нарны аймгийн 9 гариг, Сэлэнгэ аймгийн оны шилдэг сурагчид, спорт, урлаг, сурлагаар амжилт гаргасан сурагчид, Ерөө сумын танилцуулга, газарзүй, байгалийн онцлог тохижилтын ажлыг хийж гүйцэтгэлээ. Тохижилтын ажилд багш, ажилтан, суралцагч, эцэг эхчүүдийн “Эко сан”-ийн хандив 804000 төгрөг, сургуулийн төсвөөс 750000 төгрөг нийт 1554000 төгрөг зарцууллаа.

Монгол хэл, математик, замын хөдөлгөөн, эко булангуудыг байгуулсан. Мөн сурагчдын ой тогтоолт, цээжлэх, нүдлэх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор сургуулийн коридорт 150 орны төрийн далбааг хийж хадлаа.

Өвөл цагийн хүмүүжлийн ажлын хүрээнд Ерөө ЕБС-ийн захиргаанаас сургуулийн эцэг эхчүүдийн дунд “Эрүүл биед саруул ухаан оршино” уриатай сургуулийн эцэг эхийн “Цом-2020” спортын 4 төрөлт тэмцээнийг 2020 оны 1-р сарын 9, 10-ны өдрүүдэд болж өнгөрлөө. Тэмцээнд 1-12-р ангийн 9 багийн 200

гаруй тамирчин эцэг эхчүүд оролцож оюун ухаан, хурд хүч, авьяас чадвараа сорин өрсөлдлөө.

Сумын эрүүл мэндийн төвөөс амбулаториор нийт 456 иргэнийг үзлэгт хамруулж, стационарт 43 хүнийг хэвтүүлэн эмчилж, түргэн тусламжийн нийт 136 дуудлага хүлээн авснаас, алсын 17 дуудлагад явж үйлчилсэн.

2020 оны 01-р сарын 16-ны өдөр албан байгууллага, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор Соёлын төв, Спорт цогцолбороос Эрүүл мэндийн төвтэй хамтран “Эрүүл агаар, идэвхитэй хөдөлгөөн” сэдэвт Цасны баярыг амжилттай зохион байгууллаа. Уг тэмцээнд 5 багийн 40 гаруй хүмүүс хамрагдлаа.

Мандал сум:

Үндсэн хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр сургалт бэлтгэн Засаг даргын Тамгын мэргэжилтэн нар мэдээлэл хийн сургагч багш бэлтгэн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны 19 албан хаагч 19 ААНБ-ын нийт 910 албан хаагчдад 2020 оны 01 сарын 13-ний даваа гарагт “Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт” сэдвээр 30 минутын сургалт зохион байгууллаа.

Мөн сургалтаар орсон мэдээллээ бататгах зорилгоор АХА тэмцээн зохион байгуулж тэргүүлсэн 19-н албан хаагчдад 250,000 төгрөгийн бичгийн хэрэгслээр шагнаж урамшууллаа.

Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх ажлын хүрээнд баг бүр Үндсэн хуулийн сургалтыг зохион байгуулж нийт 200 гаруй иргэнийг хамрууллаа.

Сургалтын агуулга нь Монгол Улсын үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт, дагаж мөрдөх хугацаа, өөрчлөлт хийх болсон шалтгаан хэрэгжүүлэх явц мөн хуучин хууль болон нэмэлт өөрчлөлтийн ялгаа онцлогын талаар мэдээллийг хүргэж ажилласан.

Сумын амьжиргаа дэмжих зөвлөл тайлант сард 1 удаа хуралдаж байнгын асаргаанд шинээр-3, сунгалт-7, асрагч солих-2, өрх толгойлсон эцэг, эхэд олгох тэтгэмжид-2, тэжээгчийн тэтгэвэр-1 иргэн, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд 1 өрхийг хамруулахаар нийт 17 иргэний өргөдлийг шийдвэрлэв.

Дэлхийн зөн ЗХОНХХ-тэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй 6, өрхийн аж ахуй эрхлэгч 31, зорилтот өрхийн 14 гишүүн нийт 51 иргэнийг “Бизнесээ эхэл, хөгжүүл” төсөл бичих, бизнес эрхлэх сургалтанд хамруулав.

Шударга олборлолтын стандарт шаардлагуудыг хангаж гэрчилгээ авсан “Дууш Мандал хайрхан” ТББ-н гишүүдээс хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг зорилтот бүлгийн өрхийн 45 хүүхдэд шинэ жилийн бэлэг гардууллаа.

Шинээр төрсөн 47 хүүхдийг бүртгэж, өрхийн мэдээллийн санд бүртгэв. 2019 ондөрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдахаар шинээр хүсэлт ирүүлсэн 356 өргөдлөөс 347 өргөдлийг шийдвэрлэж 97,4%-ийн гүйцэтгэлтэй байсан бол тайлант сард нийт 22 өргөдөл бүртгэгдсэн байна.

Сумын хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэнд 1-р сард 36 иргэн ажил хайгчийн анкет бөглөн бүртгүүлж, Хөдөлмөр эрхлэлтийн LMIS программд цаг тухайд нь бүртгэн баталгаажуулж, 12 иргэнд ажил идэвхитэй хайж байгаа тодорхойлолт өгсөн. Шинээр ажлын байр 2 бий болж 15 иргэнийг ажлын байранд зуучилсан. Ажлын сул орон тоог Ажлын байрны захиалгын маягтын дагуу 10 аж ахуй нэгж байгууллагын 15 захиалга ирсэний дагуу 15 иргэнийг зуучлан ажилласан байна.

Зүүнхараа Политехник коллеж нь 62 багш, ажилтан албан хаагчидтай, 2020 оны 01 сарын 13-ны өдрийн 09:00 цагт “Монгол улсын үндсэн хууль”-иар нийт 41 ажилчид албан хаагчдад мэдээлэл өгч ажилласан. Мэдээлэлд Монгол улсын үндсэн хуулийн түүхэн цаг хугацаа, Төрийн бэлэг тэмдэгүүд, өөрчлөлтүүд зэрэг мэдээлэл багтсан. Мэдээлэл авсан албан хаагчдаас Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацааны талаар асуултуудыг асууж тодруулж байсан.

Ерөнхий боловсролын 4-р сургууль төгсөх ангийн сурагчиддаа “Мэргэжлээ хэрхэн зөв сонгох вэ”, багш ажилчиддаа “Байгууллагын уур амьсгал, төрийн албан

хаагчийн ёсзүй”-н сургалт захиалсаны дагуу 2020 оны 01 сарын 29, 30-ны өдрүүдэд зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Мод бэлтгэлийн талбай тусгаарлалт: Талбай тусгаарлалт хийлгэх 1 аж ахуйн нэгж, байгууллага хүсэлт гаргасаны дагуу 1 байгууллагад цэвэрлэгээний ажлаар 10 га талбайд мод бэлтгэлийн талбай тусгаарлалтын ажил хийсэн. Хэрэглээний мод бэлтгэх эрхийн бичгийг 4 аж ахуйн нэгж, байгууллага, 1 нөхөрлөлд 263 м3 хэрэглээ, 95 м3 түлээ олгож, 45 ширхэг гарал үүслийн гэрчилгээнд түлээ 218 м3, хэрэглээ 464 м3 буюу нийт 682 м3 бичиж олгосон.

Баянгол сум

Аймгийн Засаг даргын 2019 оны А/450 тоот захирамжийн дагуу сумын хэмжээнд 2020 оны цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийг 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хооронд зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан цэргийн шинэчилсэн тоо бүртгэлд 16-17 насны идэрчүүд, 18-50 насны нэг, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн болон 65 хүртлэх насны бэлтгэл офицерууд, цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүд, эмэгтэй офицер, ахлагч нарыг тоо бүртгэлд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулан бүртгэлийн ажлыг хийж гүйцэтгэн холбогдох тайлан мэдээг гарган ажиллаж байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа бүх байшин, орон сууцны сан хөмрөгийг бүрэн тодорхойлох, орон сууцны фонд, хийц, ашиглалт, хүчин чадал, дэд бүтцийн хүртээмжийн талаар дэлгэрэнгүй мэдээллийн сантай болох, Монгол Улсын сууцны суурь мэдээллийг Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн хамгийн бага нэгжийн түвшинд гаргах мөн төрөөс баримталж буй бодлого, хөтөлбөрийн төлөвлөлт болоод олон улсад гаргаж буй хөгжлийн үзүүлэлтүүдийн суурь мэдээллийг бий болгох зорилгоор сумын Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/27 тоот захирамжийн дагуу сумын тооллогын комисс байгуулагдан ажиллалаа. Сэлэнгэ аймгийн хүн ам, орон сууцны тооллогын комиссын баталсан үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу сумын тооллогын түр товчоо тооллогын шуурхай төлөвлөгөө боловсруулан батлуулж Статистикийн хэлтэсрүү хүргүүлсэн.

“Хүн ам орон сууцны ээлжит тооллого 2020”-д тоологчоор Хараа багт 01 дугаартай Э.Азжаргал, 02 дугаартай Э.Эрдэнэбат, Баян багт 01 дугаартай Д.Батцэцэг, Гонир багт 01 дугаартай Г.Баясалмаа нийт 4 тоологч, шалгагчаар Э.Эрдэм нар ажиллахаар гэрээ байгуулсан. Статистикийн хэлтсээс сумын хэмжээнд өрхийн 10 хувь болох 170 өрх буюу Хараа баг 60 өрх, Баян баг 60 өрх, Гонир баг 50 өрхөд тооллогын ажлыг амжилттай зохион байгууллаа.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/02 тоот “Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 28 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” захирамжийн дагуу Монгол Улсад Ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдаж мөрдөж эхэлсэний 28 жилийн ойн баярыг сумын хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллалаа. Төр, төсвийн 5 байгууллагад нэмэлт өөрчлөлт орсныг сургалтын материал, гарын авлага бэлдэн хүргүүлж сурталчлан ажилласан. ЗДТГ-ын ажилтан, албан хаагчдад Үндсэн хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн талаар болон Үндсэн хуулийн үүсэл, хөгжил 1924, 1940, 1960, 1992, 2019 оны Үндсэн хуулиудын өөрчлөлтийн талаар сургалт орж сурталчлан ажиллалаа. Монгол Улсын Үндсэн хуулинд орсон нэмэлт өөрчлөлтийг одоогийн байдлаар төр, төсвийн 6 байгууллагын нийт 150 ажилтан, албан хаагчдад сурталчлан ажиллаад байна. Цаашид багийн Засаг дарга нартай хамтран иргэдэд сурталчилгааны материал гарын авлага бэлтгэн сурталчлан ажиллахаар бэлтгэж байна. Үндсэн хуулийн 28 жилийн ойг тохиолдуулан Үндэсний 32 бөхийн барилдааныг 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулж тэмдэглэн өнгөрүүлээ.

2020 оны 1 дүгээр сарын 24-ны байдлаар тус сумын Эрүүл мэндийн төвд хэвтэн эмчлүүлсэн-51, Алсын дуудлага-24, Ойрын дуудлага-68, Амбулаторийн үзлэг-1021, Томуу, томуу төст өвчний эзлэх хувь амбулаторид-14.2 хувь, стационарт 41 хувь, дуудлагад 90 хувь, хяналтанд орсон жирэмсэн эх 9 хувь,

Мандал суманд төрсөн эхийн тоо-9, Чихрийн шижингийн эрт илрүүлгийн үзлэг-67, Артерын гипертензийн эрт илрүүлгийн үзлэг-67, Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэг-15, Хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэг-15, Эхо оношилгоо-28, Зүрхний цахилгаан бичлэг-15, Хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настан гэрийн эргэлт-20, Сэргээн засах эмчилгээ-56, Лабораторийн оношилгоо, шинжилгээ-98 иргэнд тус тус үйлчилгээ үзүүлж ажилласан байна.

Эрүүл мэндийн төвийн даргын 2020 оны 01 сарын 02-ны өдрийн А/01 тоот тушаалаар “Томуу, томуу төст өвчний үед уртасгасан цагаар ажиллах тухай” тушаал гаргаж ажилчид ажлын өдөр 18.00-22.00, амралтын өдөр-10.00-18.00 цаг хүртэл уртасгасан цагаар ажиллаж байна.

Баянгол сумын 1284 хүн амд гэрийн эргэлтээр очиж томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг өгсөн.

0-5 насны хүүхдийн вакциныг гэрийн эргэлтэнд шилжүүлэн гэрээр очин хийж байна.

Амралтын өдөр ЕБС-ийн дотуур байрны 139 сурагчид урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулсан.

2020 онд тариалах улаан буудайн үрийн нөөцийн судалгаа, ургамал хамгааллын бодисын захиалгыг 23 аж ахуй нэгж, 19 иргэнээс авч хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 394 тоот тогтоолын дагуу 2019 онд үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан 155 малчин, мал бүхий иргэний 9415 ширхэг падааны жагсаалтыг гаргаж, программд оруулан аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн.

Сайхан сүм:

Төрийн үйлчилгээний ил тод байдлыг нэмэгдүүлэх, иргэдэд мэдээ мэдээлэл хүргэх ажлын хүрээнд сумын цахим хуудсыг идэвхтэй ажиллуулахаас гадна энэ онд шинээр “Хөтөлийн мэдээ” сониныг сар бүр хэвлэн, иргэдэд тараах ажлыг зохион байгуулж байна. 2017-2019 онд улс, аймаг, сумын хөрөнгөөр орон нутагт хийгдсэн хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажил болон, шинээр санаачлан зохион байгуулсан ажлын танилцуулга ном хэвлүүлэн иргэдэд хүргэлээ.

2020 оны цэргийн бүртгэлийг сумын хэмжээнд зохион байгуулсан.

Аймгийн Засаг дарга Ш.Оргил, хэлтэс агентлагийн дарга нарын хамт 2020 оны 1-р сарын 16-нд тус суманд ажиллаж төр, төсвийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцан, иргэдтэй уулзалт хийлээ.

Монгол улсад Үндсэн хууль батлагдсаны 28 жилийн ойг улсын хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлж буйтай холбогдуулан Сайхан суманд Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг сурталчлан, тайлбарлан таниулах арга хэмжээг зохион байгуулж, нийт 62 албан хаагч сургалтанд хамрагдав.

2020 оны 01-р сарын 18-ны өдөр Номгон 3-р багийн малчдын дунд “Цасны баяр”-ыг зохион байгуулж, цасны сумо, олс таталд, сээр цохих, буухиа, дардас гээд 5 төрлийн тэмцээн уралдаан зохион байгуулсан.

Сумын эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нэгж нь 01 дүгээр сарын тайлант хугацаанд нийт мэдүүлэг хүлээн авч, Монгол Улсын үндсэн хууль, Иргэний тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад дээд шатны байгууллагын чиглэл заавар зөвлөмжийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 84 мэдүүлэг хүлээн авч:

- Анхны бүртгэл -52
- Өмчлөх эрх шилжих гэрээ - 11
- Барьцааны гэрээ - 17
- Бүртгэлд өөрчлөлт оруулах-1

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 65 мэдүүлэг хүлээн авсны:

- Анхны бүртгэл -5
- Өмчлөх эрх шилжих гэрээ - 9
- Барьцааны гэрээ - 49
- Бүртгэлд өөрчлөлт оруулах-1
- Лавлагаа -28 тус тус гаргаж үйлчилсэн.

Ойн тухай хуулийн хүрээнд Баруунбүрэн суманд үйл ажиллагаа явуулж байгаа ойн мэргэжлийн байгууллага болох “Шинэ-Орос хийц” ХХК болон “Хэт-жолоо” ХХК-уудын хэрэглээний 48 м3 мод, модон материалд гарал үүслийн гэрчилгээний бичилт хийж, үнэт цаасны бичилтийн тайланг Орхон бүс дэхь сум дундын ойн ангид хүргүүлсэн.

Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох МУЗГ-ын 2013.11.30-ны өдрийн 394-р тогтоолын дагуу сумын нийт 150малчин, мал бүхий иргэний 11779 –н арьс, шир буюу 394 ширхэг паданыг ARIS программд шивж холбогдох материалыг аймгийн ХХААГазар бичгээр болон файлаар хүргүүлсэн байна.

Гавшгай 2-р багийн 2, Номгон 3-р багийн 10 сумын нийт 12 иргэнд шинээр малчин өрхийн баталгааны тэмдэг буюу малчин тамгыг Хүннү тамга ХХК-д захиалгаар хэвлүүлэн малчдад хүргүүлж ажиллалаа.

Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг сумын нутаг дэвсгэрээс гадагш худалдаалах, төхөөрөх, нийтийг хамарсан арга хэмжээнд оролцуулах, хээлтүүлэгт ашиглах, отор нүүдэл хийх болон бусад зорилгоор шилжилт хөдөлгөөн хийх үед мал эмнэлэг, ариун цэвэр, гарал үүслийн баталгаажуулалтын гэрчилгээг цахимаар, нэгдсэн мэдээллийн сантай холбогдон гэрчилгээ олгож байна. Нийт 2020 оны 1-р сард гэрчилгээг цахимаар олгосон байна.

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 “а”-д заасны дагуу Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогыг 2020.01.09-өөс 15-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулагдаж дууслаа. Энэ удаагийн тооллогын онцлог нь мэдээлэл цуглуулалтын хосолмол аргаар явагдсан бөгөөд Сайхан сумын 2763 өрхийн 10% буюу 270 өрхөд уламжлал аргаар хүн нэг бүрчлэн асуулга асууж, үлдсэн өрхийг Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн системийг ашиглан тооллоо. Сайхан сумын хэмжээнд 5 тоологч 270 өрхөөр нэг бүрчлэн орж асуулга асууж хугацаандаа 100 хувийн гүйцэтгэлтэй гарсан. 270 өрхийн 950 хүн тооллогод хамрагдсан бөгөөд хаягандаа амьдардаггүй 12 өрхийг орлуулан тоолж дуусгасан байна.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу гэр бүлийнхэрэгцээний зориулалтаар 1 дүгээр сар засаг даргын 1 удаагийн захирамжаар 52 иргэн нийт 36400 м2 газрыг үнэ төлбөргүй өмчлүүлэх шийдвэр гарсан. Хамтран өмчлөл салгуулсан иргэн байхгүй, өмчлөлийн газраа эрх шилжүүлсэн 5 иргэн, газар эзэмшлийн гэрчилгээгээ банк санхүүгийн байгууллагад барьцаалж, барьцаанд бүртгүүлсэн 1 иргэн, чөлөөлсөн байхгүй мөн газрын харилцаатай холбоотой 11 иргэнд тодорхойлолт олгосон.Улсын бүртгэлд 1 дүгээр сард газрын тухай хуулийн дагуу үнэ төлбөргүй газраа өмчилж улсын бүртгэлд 43 иргэн бүртгэгдсэн бөгөөд шинээр өвөлжөөний газраа эзэмшиж гэрээ, гэрчилгээжүүлэн улсын бүртгэлд бүртгүүлсэн 7 иргэн тус тус бүртгэгдсэн байна. Эзэмшил газрын эрхээ бусдад шилжүүлсэн 3 иргэн, аж ахуй нэгж бүртгэгдсэн.

Мөн газрын төлбөр татварын албаруу шилжиж байгаатай холбогдуулан мэдээллийн санд ороогүй нэгж талбаруудыг нөхөн бүрдүүлэх ажил хийгдэж байгаа бөгөөд 1 сарын байдлаар 107 нэгж талбарыг нөхөн бүрдүүлж ажиллалаа

ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтийн тайлантай холбоотой 56 татвар төлөгчийг, татвар төлөгчийг бүртгэх журмын дагуу бүртгэн цахим програмууд дээр хэрэглэгч үүсгэн тохиргоонуудыг тухай бүр хийн иргэний цэнхэр дэвтэр олгож ажиллалаа. Шинээр хуулийн этгээд болсон 1 аж ахуйн нэгжийг журмын дагуу бүртгэн цахим тоон гарын үсэг олгон зөвлөгөө өгч, бүртгэлдээ нэмэлт өөрчлөлт

оруулж байгаа 4 татвар төлөгчийн материалыг хүлээн авч холбогдох програмд бүртгэсэн.

Тайлант хугацаанд сумын хэмжээнд 4 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд ханиад томууны өвчлөл их байгаагаас шалтгаалан хүүхэд хүлээн авах үйл ажиллагааг түр хугацаанд зогсоон ажилласан. Цэцэрлэгийн эрхлэгчид аймаг, сумын Засаг даргатай байгуулсан 2019 оны үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг тайлагнан, 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

“Орхон” бүсийн багш нарын “Оны шилдэг илтгэл” шалгаруулах уралдааныг зохион байгуулсан. Уг илтгэлийн уралдаанд 8 сургууль, 5 цэцэрлэг оролцож олон шинэлэг санаа, тэргүүн туршлагаа түгээж хамтран ажиллалаа. Уралдаанд 13 илтгэл оролцсоноос ерөнхий боловсролын сургуулиудаас 1-р байранд 87,2 оноогоор Сайхан 2-р сургууль, 2-р байранд 86,5 оноогоор Орхон ЕБС, 3-р байранд Сайхан сумын 1-р сургууль, цэцэрлэгүүдээс 1-р байранд 74,9 оноогоор Орхон сумын цэцэрлэг, 2-р байранд 65,5 оноогоор Сант сумын цэцэрлэг, 3-р байранд 61,9 оноогоор Номгон сумын цэцэрлэг тус тус шалгарлаа. Нийт шалгарсан илтгэлүүдийн хамгийн өндөр оноотой Сайхан сумын 2-р сургуулийн илтгэлийн баг аймгийн уралдаанд оролцох эрхтэй боллоо.

Тайлан хугацаанд сумын хэмжээнд 2 эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж, иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. 2019 оны 12 сарын 19-өөс 2020 оны 1 сарын 20-ны өдрүүдэд нийт дуудлага 102, амьсгалын замын эмгэгтэй хүүхдийн дуудлага 37, оройн цагаар нэмэлтээр хийсэн гэрийн эргэлт 125, амьсгалын замын эмгэгээр хүндэрч ЭХЭМҮТ-д хүргэгдсэн 0-11 сартай хүүхэд 2, амбулаторийн нийт үзлэг 1917, 0-10 хүртлэх хүүхдийн үзлэг 285 байна. Нийт дуудлагыг долоо хоноогоор харьцуулахад сургууль, цэцэрлэгүүдэд хөл хорио тогтоосон хугацаанд томуугийн өвчлөл буурсан байна. Нийт дуудлага 1,2-р долоо хоногт их, 2,4-р долоо хоногт цөөрсөн үзүүлэлттэй байна.

Орхон сүм:

Монгол Улсад ардчилсан “Үндсэн хууль” батлагдсаны 28 жилийн ойг Орхон сумаас сонгогдсон Ардын их хурлын депутат, Монгол Улсын гавъяат эдийн засагч А.Амжаа агсаны нэрэмжит болгон сумын ард иргэд, оюутан залуучуудын дунд гар бөмбөг, Монгол Улсын “Үндсэн хуулийг хэн сайн мэдэх вэ” АХА, шагайн харваа тэмцээнүүдийг тус тус зохион байгуулж хуулийг сурталчлан ажиллалаа.

Аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй “Хоггүй цэвэрхэн Сэлэнгэ” аяны хүрээнд “Гудамж талбайд ил задгай үнс нурмаа хаяхгүй байцгаая” аян зарласантай холбогдуулан БОХУБайцаагч, багийн Засаг дарга нартай хамтран сумын төв болон 2-р багийн суурин газрын айл өрхүүдээр явж үнс нурмаа ил задгай хаяхгүй байх мөн зориулалтын сав болон ухсан нүх зэргийг шалган айл өрх, албан байгууллагуудаар явсан. Тус ажлын хүрээнд нийт төр төсвийн 5 байгууллага, сумын төвийн 45 айл өрх, 2-р багийн 26 айл өрхүүдээр орж зарим нэг шаардлага хангаагүй ил задгай үнс нурмаа хаясан 7 айл өрхүүдэд шаардлага тавин зориулалтын үнс нурмаа хийх пошигтой болгосон.

2019 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогын дүн, холбогдох судалгаануудыг гаргаж нэгтгэсэн. Тооллогын тайланг аймгийн Статистикийн хэлтэст хүргүүлсэн. Мал тооллогын дүнгээр адуу 5837, үхэр 11624, хонь 42712, ямаа 43182 бүгд 105333 толгой мал тоологдсон. Сумын нийт мал өнгөрсөн оныхоос 6,7 хувиар өссөнөөс адуу 1,6 хувиар буурч, үхэр 1,6 хувь, хонь 4,4 хувь, ямаа 11,6 хувиар тус тус өсч, малын нийт өсөлт 7097 толгой малаар нэмэгдсэн дүнтэй байна. 2019 онд сумын нийт, малчин өрх 199, мал бүхий өрх 197 бүгд малтай 399 өрхөөр бүртгэгдсэн байна.

Баруунбүрэн сумаас мод тээвэрлэсэн 6 тээврийн хэрэгслийн 98 метр куб модны тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж, гарал үүслийн гэрчилгээгүй

мод тээвэрлэсэн Баруунбүрэн сумын 2 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу тус бүр 50.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцсон

Сумын хэмжээнд ус хангамж, ариутгах татуургын судалгаа мэдээллийг гаргаж аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн.

Тайлант хугацаанд 2019 оны мал тэжээвэр амьтны тооллогод хамрагдсан малчин, мал бүхий нийт 122 өрхий мэдээлэлийн программд шивж орлууллаа.

ДЗОУБ-аас 01 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулласан аавуудад зориулсан сургалтанд нийт 40 аавыг хамруулсан.

Сумын эрүүл мэндийн төвөөс энэ сард нийт эмчийн үзлэг 369, Үүнээс: Урьдчилан сэргийлэх үзлэг 95 буюу 25,7%-тай байгаа нь өмнөх оны 1 сартай харьцуулахад 28,7%-иар буурсан байна.Сумын эмнэлэгт 22 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлж 154 ор хоног ашигласан ба дундаж ор хоног 7 байна. Хөдөөгийн багт 2 удаагийн явуулын амбулаторийн тусламж үйлчилгээг 15 айл өрхийн 45 иргэнд үзүүлж, эрүүл мэндийн зөвлөгөө өгсөн. Нийт жирэмсний хяналтанд 21 эх хянагдаж, энэ сард шинээр жирэмсний хяналтанд 2 бүртгэгдэн үүнээс эхний 3 сартайд-2 буюу 100 хувьтай хамрагдсан. Эх нярайн эндэгдэл бүртгэгдээгүй. Умайн хүзүү, хөхний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт хамрагдах 100 эмэгтэйн судалгааг ЭМГ-т хүргүүлсэн.

Сумын хэмжээнд 0-5 насны хүүхдийн судалгааг шинэчлэн гаргаж нийт бүртгэлтэй 150 хүүхдээс 70 хүүхдийг 46,6 хувь, ахмад настан 180-аас 79 ахмадыг 43,8 хувьтай гэрийн эргэлт хяналтанд хамруулсан.

Сурагчдыг амралттай байх хугацаанд ажлын байрны орчин нөхцлийг сайжруулах, ажлын байран дээрээ өөрийгөө хөгжүүлэх, III дугаар улирлын хичээл, сургалтын үйл ажиллагааг хангах үүрэг даалгавар өгч ажиллалаа. Сурагчдын амралтын хугацааг сунгасантай холбогдуулан АУБ нар мэргэжлийн багш нартай хамтран ангийн сурагчдынхаа гэрээр хийх даалгаврыг цахимаар хүргэхийн зэрэгцээ гэрээр нь зочлон эцэг эх, сурагчидтай уулзаж, цаасан хэлбэрээр даалгаврыг хүргэж, томуу, томуу төст өвчнөөс хэрхэн сэргийлэх талаар мэдээлэл өгч, брошур, сэрэмжлүүлэг хүргэн ажиллаж байна.

Сумын шинэ жилийн баяраар Орхон ерөнхий боловсролын сургууль-“Шилдэг байгууллага”, “Шилдэг төрийн албан хаагч”-аар нийгмийн ажилтан Б.Ганчимэг, “Тэргүүний сурагч”-аар 12а ангийн сурагч Ө.Номин-Эрдэнэ нар шалгарсан. Өвлийн өвгөн аавын гарын бэлгээр 8а ангийн сурагч Т.Энххүслэн шагнагдлаа.

Орхон сумын 1-р цэцэрлэгийн хамт олон 2020 оны 01 –р сарын ажлын төлөвлөгөөндөө дараах ажлуудыг төлөвлөлөө.Төлөвлөсөн ажлуудаа цаг хугацаанд нь багтаан үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна.1-р цэцэрлэгийн хамт олон 2020 оны 01-р сард хичээл хөгжүүлэх үйл ажиллагаанд 1900 хүүхэд хүлээн авч ажиллахаас бага бүлэгт 27, дунд бүлэгт 32, ахлах бүлэгт 37 хүүхэд, бэлтгэл бүлэгт 49 хүүхэд, нийт 145 хүүхдийг хичээл хөгжүүлэх үйл ажиллагаанд хамруулан ажилласан байна. Хүүхдийн ирцийн буурсан шалтгаан нь томуу томуу төст өвчний дэгдэлтийг таслах зогсоох арга хэмжээний хүрээнд үйл ажиллагааг түр хугацаагаар хаасантай холбоотой байна.

Орхонтүүл сүм:

Сумын Засаг даргын Зөвлөл тайлант сард 1 удаа хэлэлцэж иргэдээс ирүүлсэн өргөдлүүд болон цаг үеийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж ажиллалаа. Тайлант сард иргэдээс нийт 6 өргөдөл хүсэлт ирүүлсэн байна. үүнээс ажил хүссэн 5 өргөдөл шилуин орохыг хүссэн 1 өргөдөл тус тус ирсэнийг шийдвэрлэж хариуг албан тоотоор хүргүүллээ. 2020оны 1-р сар ын 13-ны өдөр үндсэн хуулийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлсэн бөгөөд иргэдийн дунд гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулж,Үндсэн хуулийн өөрчлөлтийн тухай хууль эрх зүйн сургалт зохион байгуулан ажиллалаа. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого суманд 2020 оны 01 дүгээр сарын 09-өөс 15-ны хооронд амжилттай явагдаж ээлжит тооллогод хамрагдвал зохих нийт 110 өрх тоологдсон байна.

Иргэдийн хууль эрхзүйн мэдлэг мэдээллийг тасралтгүй дээшлүүлэх ажлын хүрээнд 2020 оны 3-р сарын 1-нийг хүртэл 7 хоногт 2 удаа хууль эрхзүйн сургалт хийх хуваарь гарган баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Сумын Засаг даргын 2019 оны хийсэн ажлын тайланг иргэдэд хүргэх сурталчилан таниулах хуваарь гарган сумын хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна.

2020 онд МЭҮН-н үйлчлэх өрхийн товчооны нэгтгэлийг хүснэгтийн дагуу хуваарилаж, цаашид мал эмнэлгийн ажил үйлчилгээг явуулах гэрээ байгуулан ажиллах нөхцөлийг ханган ажиллаа. Сумын хэмжээнд малчин, мал бүхий 749 өрхөөс Сүргийн-Ундраа МЭҮН 339 өрхийн 83480 толгой малд, Анар-Уул МЭҮН 242 өрхийн 71417 толгой малд, "Сэлэнгэ гранд" МЭҮН 168 өрхийн 57663 толгой малд мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх өрхийн товчооны нэгтгэлийг Засаг даргад танилцуулж баталгаажуулан, хүснэгтийн дагуу нэгтгэн холбогдох мэргэжилтэнд хүргүүлээ.

2019 оны жилийн эцсийн дүнгээр 212560 толгой мал тоологдож, үүнээс тэмээ 396, адуу 14171, үхэр 17282, хонь 101313, ямаа 79398 толгой, 97921 хээлтэгч, 1730 хээлтүүлэгч, 71799 төл тус тус тоологдсон байна. Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг сумын нутаг дэвсгэрээс гадагш худалдаалах, нийтийг хамарсан арга хэмжээнд оролцуулах, отор нүүдэл хийх болон шилжилт хөдөлгөөн хийх үед мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд, багийн дарга нартай хамтран ариун цэвэр, гарал үүслийн гэрчилгээг цахим системээр баталгаажуулж нэгдсэн мэдээллийн сантай холбогдон гэрчилгээ олгож байна. Малын гарал үүслийн гэрчилгээ цахим системд шинжилсэнтэй холбоотой мэдээллийг малчид болон иргэдэд биечлэн танилцуулахын зэрэгцээ зарлалын самбарууд болон сумын цахим хаягаар дамжуулан сурталчилан ажиллаж байна. Мал эмнэлгийн гэрчилгээ цахим нэгдсэн системд шилжсэнээс хойш сумын хэмжээнд хүнсний зориулалтаар тэмээ 5, адуу 6, үхэр 18, ямаа 44, хонь 64 нийт 137 толгой мал, үржлийн зориулалтаар гаднаас 14 адуу, үзэсгэлэн, уралдааны зориулалтаар 6, отор нүүдлийн зориулалтаар 2 нийт 22 тооны адуу ирсэн байна.

Орон нутгийн төсвийн байгууллагуудын төсвийн сар улирлын хуваарийг хийж, Засаг даргын захирамжаар баталгаажуулан аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлэн төсвийн программд оруулсан. Орон нутгийн 2020 оны төсвийн жилд төвлөрүүлэх зарлагын нийт 3385676,9 мянган төгрөгөөр батлагдсан байна. ОНХС-аар хийгдсэн ажлуудаар гарын авлага хийж иргэдэд танилцуулж, СХС-ын программд зээлдэгчдийн мэдээллийн бүрэн оруулсан байна.

Хушаат сум:

Хушаат сумын шинэ жилийн баяр өвлийн өвгөн, цасан охин, алиалагч, аваргууд, төрийн одон медаль гээд юм юмтай сайхан баяр болж төрийн албанд олон жил ажилласан С.Цэдэн-иш "Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон"-гоор, Т.Энхмядаг "Хүнс, хөдөө аж ахуйн тэргүүний ажилтан"-аар, Түвшинжаргал, В.Даваадорж нар МУЗГ-ын "Атар -60 ойн медаль"-иар, Ц.Дэнсмаа, М.Мөнхчулуун нар аймгийн Атар 60 ойн медалиар тус тус шагнуулсан. Мөн 2019 оны шилдэгүүдээ шагнаж урамшууллаа. Сумын "Шилдэг тохижилттой өрх"-өөр Н.Жаргалбатынх, "Шилдэг хөдөлмөрч залуу"-гаар Г.Бат-очир, "Шилдэг нийгмийн хариуцлагаа ухамсарлагч ТББ"-аар "Эко Хушаат" хоршоо, "Шилдэг төрийн байгууллагын ажилтан"-аар Д.Өнөржаргал, "Шилдэг тариаланч"-аар Г.Энхтайван, "Шилдэг ногоочин"-оор Ц.Дэнсмаа, "Шилдэг уяач"-аар Ш.Баянжаргал, "Шилдэг сурагч"-аар О.Эрдэнэчулуун нар шалгарлаа. ЕБС-ийн байгууллагын аваргаар Т.Энхтүвшин, Г.Мэндбаяр, Н.Уранчимэг, сурагч Ц.Цэлмэг, Л.Отгонбаяр багштай 7-а анги, Б.Улаанаа багштай 3-а анги шалгарлаа. Спортын дэд мастер Г.Батцэцэг, С.Шинэхүү, Б.Батзориг, Г.Мөнхтуяа, Ж.Цэнгүүнбаяр нарын амжилтыг үнэлэн сумын Засаг даргын Жуух бичгээр шагнаж урамшууллаа. Сумын малчин Хаянхярваа тамирчдын бэлтгэлийг хангах зорилгоор нийт 2,0 сая төгрөгийг тамирчдад өгч тусаллаа. Мөн сумын Засаг даргын Жуух бичгийг сумын ЗДТГ, ХАА-н банкинд олон жил ажиллаж байгаа З.Олонбаярт олгон урамшууллаа. Сумын Эмэгтэйчүүдийн

холбооноос аймгийн Эмэгтэйчүүдийн холбооны зөвлөлийн дарга Д.Өнөрболорын мэндчилгээг нийтэд хүргэн сугалаат хонжворын эздийг тодрууллаа.

Шинэ Үндсэн хууль батлагдсаны 28 жилийн ойг тохиолдуулан Сэлэнгэ аймгийн Хушаат сумаас Ардын Их Хуралд депутатаар сонгогдон Үндсэн хуулийг батлалцсан шинээр дахин байгуулагдсан Хушаат сумын анхны Засаг дарга Х.Намсрайжавын талаар нийтлэлийг сумын цахим хуудсуудаар танилцууллаа. Ойг тохиолдуулан Ардын Их Хурлын депутат Халтарын Намсрайжавын нэрэмжит шатрын тэмцээнийг 7 дахь жилдээ зохион байгууллаа. Тэмцээнийг шатрын спортын мастер Сүхийн Цэдэн-иш тэргүүлж шатрын спортын зэрэгтэй тамирчин Түвдэнгийн Гэрэлтуяа, Гарамжавын Баяраа нар удааллаа. Тэмцээнийг Х.Намсрайжав агсны үр хүүхдүүд, ЗДТГ хамтран зохион байгууллаа. Мөн сумын ЕБС, Цэцэрлэг, Соёлын төвийн ажилтнуудын дунд "Шинэ үндсэн хуулийн видео хичээл", "Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт" сэдвүүдээр хууль эрх зүйн сургалт явуулж Хушаат сумаас 1988-1992 онуудад АИХ-ын депутатаар сонгогдон ажиллаж Шинэ Үндсэн хуулийн батлалцсан, Халтарын Намсрайжав агсаны талаар дурсамжийг танилцууллаа. Сургалтаа бататган АХА тэмцээнийг зохион байгуулж 1-р байранд багш Н.Уранчимэг, 2-р байранд багш Ц.Долгорсүрэн, 3-р байранд Соёлын төвийн үйлчлэгч Г.Батцэцэг нар шалгарлаа.

Монгол Улсын хүн ам, орон сууцны ээлжит тооллогын ажлын хүрээнд сумын тооллогын комисс багийн түр товчоотой хамтран 2020.01.08-ны өдөр хуралдаж тоологч, шалгагч нарт үүрэг чиглэл өгч шаардагдах тооллогын асуулгын маягт болон бусад баримт бичиг, материалыг хүлээлгэн өглөө. 2020.01.09-ны өглөө 09:00 цагаас улс орон даяар эхэлж Сэлэнгэ аймгийн Хушаат суманд хамгийн эхний тооллогыг 1-р багийн иргэн Д.Нармандах гуайнхаас эхлүүллээ. Анхны тооллогын бүрэлдэхүүнд Засаг дарга Б.Атартулга, 1-р багийн засаг дарга М.Жаргал, 2-р багийн Засаг дарга Г.Мөнх-эрдэнэ, тоологч Б.Наранжаргал, Ж.Алтанцэцэг, шалгагч Б.Сэлэнгэ нар ажиллалаа.

Сумын төр төсвийн байгууллага, багуудын дунд зохион байгуулагддаг "Цасны баяр" зохион байгуулагдлаа. Цасны баярт сумын Тамгын газар, Соёлын төв, Эрүүл мэнд төв, Цэцэрлэг, 1-р багийн хамт олон оролцлоо. Цасны баярын Эрүүл Мэндийн Төвөөс зохион байгуулсан тэмцээнд Соёлын төв, Тамгын Газар, 1-р багийн хамт олон, Соёлын төвөөс зохион байгуулсан поошигтой буухиа тэмцээнд ЭМТ, 1-р баг, Цэцэрлэгийн хамт олон, Цэцэрлэгээс зохион байгуулсан чаргатай буухиа тэмцээнд Соёлын төв, Сумо тэмцээнд Ж.Бат-эрдэнэ, Алтаншагай, Ганбат нар, ЗДТГ-аас зохион байгуулсан олс таталтын тэмцээнд ЭМТөв, Цэцэрлэг, 1-р багийн хамт олон эхний байруудыг эзэллээ.

Сумын ИТХ-аар 2020 оны төсөвт төвлөрүүлэх орлогыг 56 729.4 мянган төгрөгөөр, сумын төсөвт аймгийн төсвөөс шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг 1 080 549.2 мянган төгрөгөөр аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 573 167.2 мянган төгрөгөөр, сумын ОНХСанд аймгийн ОНХСангаас олгох орлогын шилжүүлэг 67 766 мянган төгрөг, төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 1 789 498.6 мянган төгрөгөөр тус тус баталлаа.

Энэ сард сумын Засаг Даргын 2019 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн А/17 тоот захирамжийн хүрээнд төлөвлөгөө гарган түүний дагуу хүн ам, орон сууцны тооллогыг зохион байгуулж ажилласан. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогонд сумын нийт өрхийн 10%-ийн өрхийн нэрс түүвэрлэгдэн ирж 2020 оны 1 дүгээр сарын 9-ны өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд 66 өрхийн 267 иргэнийг хамруулж, тухай бүрт нь явцын мэдээг программаар дамжуулж ажилласан.

Сумын Газар зохион байгуулалтын 2020 оны төлөвлөгөө 2019 оны ИТХ-ийн 2019.12.19-ний 03 дугаар тогтоолоор батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна. Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгаас гэрчилгээ авах хүсэлтэй 5 иргэн, 2 Аж ахуйн нэгжийн 23 нэгж талбарын материалыг бүрдүүлж шийдвэрлэсэн. Газар өмчилж авах хүсэлтэй 4

иргэн, эрх шилжүүлэх 1 иргэн, өмчлөл газраа худалдах 2 иргэн материал шийдвэрлэсэн.

Хяналт шалгалтаар 1 удаа хөдөөгийн чиглэлд явж 1 иргэнд 342.000 төгрөгийн нөхөн төлбөр оногдуулж эрүүгийн хэрэг үүсгүүлэн хулийн байгууллагад шилжүүлсэн. Ойгоос түлшний мод ашигласны төлбөрт 158 860 төгрөг төвлөрүүлж нийт 26 өрхөд 100м³ түлшний мод бэлтгэх эрхийн бичиг олгосон байна.

Сумын төвийн 83 өрх, аж ахуйн нэгж, дэлгүүрээр 5 өдөр явж ажиллав. Мөн татварын улсын байцаагчийн хамтаар 2019 оны хог хаягдал үүсгэсний төлбөрийн дутууг авахаар мэдэгдэл өгөх, түлээний модны эрхийн бичгийн хяналтын ажлуудыг хийлээ.

Сум хөгжүүлэх сангийн 2011-2018 оны зээлтэй 32 нэр бүхий иргэдэд тус бүр 2 удаа мэдэгдэх хуудас тарааж мэдэгдсэн. Шүүхийн эрвэлүүлэн зуучлалаар орсон 9 иргэнийг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд өгөхөд материал бэлэн болсон.

Цахим гарал үүслийн гэрчилгээний системийн сургалтанд сууж гарал үүслийг 2020 оны 1-р сарын 16-ны өдрөөс хэрэгжүүлэн гарал үүслийг цахимаар олгож байна. Мөнхтолгой 2-р багаас ХАОС-ны тооллогод 35 өрхийн 139 иргэнийг хамруулан тоож асуулгын маягтыг тухай бүр хянан баталгаажуулж сумын тооллогын комисст хүлээлгэн өгч ажиллав.

Зүүнбүрэн сум:

Дээд байгууллага албан тушаалтнаас 55 албан бичиг ирснээс 22 албан бичиг нь хугацаатай, хугацаа болоогүй 9, хугацаандаа явсан 13 бичиг байна.

Сумын Засаг даргаас нийт 8 захирамж гарснаас үйл ажиллагааны холбогдолтой 5 захирамж гарч хэрэгжилтийг ханган ажиллаж, иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу ажилд орохыг хүссэн 1 өргөдөл ирсэн нь шийдвэрлэх шатандаа явж байна.

2020 оны 01 дүгээр сард шинэ төрсөн 5, гэрлэсний 1, нас барсны 1, шилжин ирсэн 4, иргэний үнэмлэх олголтын 18, иргэний үнэмлэх дахин олголт 1, Биеийн давхацахгүй өгөгдлийн бүртгэл 5 нийт 35 бүртгэлийн ажлыг хийж гүйцэтгэлээ. 2004 онд төрсөн, тухайн жилд 16 нас хүрч иргэний үнэмлэх шинээр авах хүүхдүүдийн судалгааг гаргаж, мэдээллийн сан дахь хаягийн болон бусад зөрчлийг арилгахаар ажиллаж байна.

2019 оны сумын суурин хүн амын тоо 2899 байгаагаас 1419 эрэгтэй, 1480 эмэгтэй, 823 өрх тоологдсон байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж сонгогчдын нэрийн жагсаалтыг үнэн зөв үйлдэх, иргэний оршин суугаа хаягийн мэдээллийн санг цэгцлэх ажлыг хэрэгжүүлж иргэний бүртгэлийн мэдээллийн санд хаяггүй төлөвт байгаа иргэдийн жагсаалтаас өөрийн сумаас шилжин явсан боловч очсон газраа бүртгүүлээгүй 2 иргэнтэй утсаар холбогдож 02 дугаар сарын 01 –нээс өмнө оршин суугаа газраа бүртгүүлэх тухай зөвлөж санууллаа.

Аймгийн Засаг даргын 2020 оны “Монгол Улсын үндсэн хууль батлагдсаны 28 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай А/02 тоот захирамжийг Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 3/03 тоотоор төр, төсвийн байгууллагуудад хүргүүллээ.

Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаарх мэдээллийн Zuunburen ZDTG, Zuunburen заг зэрэг цахим хаягаар дамжуулан иргэдэд сурталчиллаа.

Томуу томуу төст өвчин болон короновирусын талаарх сурталчилгааг 35 иргэнд хийлээ.

Цагдаагийн байгууллагаас зохион байгуулж буй “Ятгах тусам нягтал” нөлөөлийн арга хэмжээг зохион байгуулж уг аянд нэглээ.

Сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг сайжруулсан хөтөлбөрийн дагуу сар өдрийн хичээлийн төлөвлөгөөг боловсруулан бэлтгэн ажиллаж байна. 1 дүгээр цэцэрлэгийн 9 өрөөнд камер суурилууллаа. Багш ажилчдын хувцас солих өрөөнд засвар хийлээ.

“Орон зайнаас үл хамааран суралцья, ажиллая” сургалтын менежерүүдийн чадваржуулах төслийн сургалтад 10 багш хамрагдаж, Мандал IV сургууль дээр Олон улсын Эко сургуулийн Ахисан түвшний 2 дахь сургалтад насан туршийн боловсролын төвийн багш хамрагдлаа.

Мөн 5 дугаар ангийн 2 багш “Чанарын үнэлгээ, улсын шалгалтын анги дэвших шалгалт, сургалтын чанарыг сайжруулахад анхаарах” асуудлыг хэлэлцэн багш нараас шалгалт авсан.

Г.Цоожсүрэнгийн бэлтгэсэн шавь Ж.Төрболд Жюү Жицүгийн МУ-ын аварга шалгаруулах өсвөр үе, залуучуудын 6 дахь удаагийн тэмцээнд амжилттай оролцож 3-р байр хүрэл медаль хүртлээ.

Мэргэжлийн багш нар 12 дугаар ангийн 33 суралцагч, эцэг эхтэй гурвалсан гэрээг сургуулийн захирал, сургалтын менежер, анги удирдсан багш хамтран байгуулан гэрээнний дагуу ажиллаж байна.

Сумын Эрүүл мэндийн төв 38 иргэнийг хэвтүүлэн эмчил, амбулатороор 252 иргэнд үзлэг хийснээс өвчний учир 154, урьдчилан сэргийлэх үзлэгээр 23, диспансерийн хяналтаар 28, гэрийн идэвхтэй эргэлтээр 13, дуудлагаар 34 иргэнд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүлээ. Амьсгалын замын халдварт өвчнөөр 0-5 насны 22 хүүхэд өвчлөн хэвтүүлэн эмчиллээ.

Өвөлжөө, хаваржаа, төмс, хүнсний ногооны зориулалтаар газар эзэмших 9, шинээр гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчлөх 43 өргөдлийг хүлээн авсан. Гэрээ, гэрчилгээгээ шинэчилэх хүсэлтэй 26 иргэн, аж ахуй нэгж байгууллагын 38 нэгж талбарын мэдүүлгийг хүлээн авч үйлчилж, өмнөх оны 103 нэгж талбарын хувийн хэргийг улсын бүртгэлд бүртгэж, хувийн хэргийн бүрдүүлэлтийг хангаж архивт хадгаллаа.

Арьс ширний урамшуулалд 71 өрхийн 4215 арьс ширний материалыг бүрдүүлэн холбогдох дээд шатны байгууллагад хүргүүллээ. Жимс жимсгэний хураалтын мэдээг ХАА-5 маягтаар гарган ХАА-н программд шивж оруулсан. Нийт 19,15 тонн үүнээс чацаргана 17,3 тонн, үхрийн нүд 18,85 тонн байна.

Сумын хэмжээнд мал бүхий 513 өрхөөс “Энхбүрэн сүрэг” МЭҮН 250 өрхийн 48995 толгой мал, “Оюутсүрэг” МЭҮН 263 өрхийн 33019 толгой малын нэгтгэлийг сумын Засаг даргаар баталгаажуулан холбогдох дээд шатны байгууллагад хүргүүллээ. 2019 оны жилийн эцэст 83231 толгой мал тоологдсоноос адуу 4511, үхэр 13155, хонь 34814, ямаа 30751 тус тус тоологдсон байна.

Иргэдийн өөрсдийн хүнсний хэрэгцээ болон зах зээлд борлуулахаар бэлтгэсэн 2305 кг малын мах, 8 толгой үхэр, 13 хонь, 5 ямаа 12 ширхэг бяслаг, 130 л сүүнд мал эмнэлгийн цахим гэрчилгээг олгож ажиллалаа.

Цагааннуур сум:

“Хүн ам орон сууцны тооллого-2020” сэдэвт тоологч, шалгагч нарт зориулсан сургалт 01 дүгээр сарын 04-06-ны өдрүүдэд Сэлэнгэ аймагт зохион байгуулагдаж сумын тоологчид сургалтанд хамрагдсан. Улс даяар 10 жилд нэг удаа зохион байгуулагддаг улсын тооллого 2020 оны 01 сарын 9-15 хооронд зохион байгуулсан. Тооллогод сумын нийт өрхийн 10 хувь буюу 140 өрхийн 563 гишүүн уламжлалт тооллогод хамрагдахаар түүвэр ирж, тооллогын хугацаанд 3 тоологч судалгааг авч өдөр өдөрт нь явцын мэдээ хүргүүлж шалгагч шивж, сум баталгаажуулан ажилласан. Тооллого нь 140 өрхийн 557 хүн тооллогод хамрагдаж өрх 100 хувь, өрхийн гишүүд 98,9 хувийн гүйцэтгэлтэй ажилласан. Аймгийн Статистикийн хэлтсээс ирсэн албан тоотын дагуу 17-19-ны өдрүүдэд сумын тооллогын даргын гаргасан 14 өрхөөр хяналтын тооллого асуулга авсан. Хүн ам орон сууцны тооллогын судалгаа маягтыг Сэлэнгэ аймгийн Статистикийн хэлтэст хуваарьт 22-ны өдөр 1-р баг буюу 30 өрхийн 30 маягтыг хүлээлгэн өгч, үлдэх 110 өрхийн судалгааг хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.

2020 оны цэргийн бүртгэлийг 1 дүгээр сарын 08-23-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Дани-Монголын нийгэмлэгтэй хамтран 01 дүгээр сарын 03-07-ны өдрүүдэд иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд “Бизнесээ эхэл, бизнесээ хөгжүүл” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Аймгийн Татварын хэлтсийн дарга, ТУАБ Д.Цэрэнболдоор ахлуулсан ажлын хэсэг тус суманд ажиллаж, жилийн эцсийн тайлан хүлээн авахтай холбогдуулан ХХОАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар сургалт, мэдээлэл 01 дүгээр сарын 10-ны өдөр хийлээ. Уг сургалтанд сумдын 3 байцаагч, 45 иргэн хамрагдлаа.

Сургууль цэцэрлэг орсонтой холбогдуулж Сургуулийн гал тогоо, цэцэрлэгийн гал тогоогоор орж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлээ. Мөн 2 дугаар багийн шинээр баригдсан цэцэрлэг 2020 оны 01 дүгээр сарын 20-ноос эхлэн ажиллаж байгаатай холбогдуулан цэцэрлэгийн гал тогоо, хүүхдүүдийн орчин, үдийн цайнд хяналт тавьж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллалаа.

Иргэдийг хилийн зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор Хилийн цэргийн 0243 дугаар ангитай хамтран 2020 оны 1 дүгээр сарын 25-нд иргэдэд хууль сурталчлах ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

“Үдийн цай” хөтөлбөрийг “Үдийн хоол” хөтөлбөр болгон өргөжүүлсний дагуу Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн хоол” хөтөлбөрийн амталгаат өдөрлөгийг 2020 оны 1 сарын 3-ны өдөр зохион байгууллаа. Амталгаат өдөрлөгт 6 төрлийн шүүс, ундаа, 7 төрлийн боов, жигнэмэг, 15 нэр төрлийн I болон II хоол, зууш, салат зэргийг бэлтгэн сумын иргэдэд үйлчиллээ. Энэ арга хэмжээнд сумын удирдлага болон төр төсвийн байгууллага, иргэд хөдөлмөрчид санал сэтгэгдлээ солилцлоо.

Монгол Улсад шинэ Үндсэн хууль батлагдсаны 28 жилийн түүхт өдрийг тохиолдуулан Үндсэн хуулийн ач холбогдол, түүхэн замнал нөхцөл байдлуудын талаар иргэдэд мэдээлэх, сурталчлан таниулах мөн сум орон нутгаас хууль батлалцаж төр нийгэмдээ үнэтэй хувь нэмэр оруулж байсан Ардын их хурлын депутатад хүндэтгэл үзүүлэх, иргэд олон нийтэд мэдээлэх ажлыг 2020.01.13-16-ны өдрүүдэд зохион байгууллаа. Иргэд олон нийтэд Үндсэн хуулийн мэдлэг олгох зорилгоор “Монгол Улсын Үндсэн хууль” цуврал шторкийг албан ёсны цахим хуудсанд байршуулан, Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаар гарын авлага, мэдээлэл бэлтгэн тараасан. Үндсэн хууль батлалцсан 1990-1992 оны Ардын Их Хурлын депутат, Монгол улсын гавъяат механикжуулагч Н.Дэлгэрмөрөнтэй Үндсэн хууль батлалцсан тухай ярилцлага хийж хүндэтгэл үзүүлэн, дурсгалын зүйл гардууллаа. Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт сэдвээр иргэд төрийн албан хаагчдад сургалт, видео хичээл, асуулт хариултын АХА тэмцээн зохион байгуулсан.

“Бүтээлийн нуур” ХХК, “Шинэ бадрах” ХХК-ий бөөрөнхий болон зүсэх материалуудыг 01 дүгээр сарын 07-ны өдөр тоолсон. Тооллогын ажлыг Сэлэнгэ бүсийн сум дундын ойн ангийн инженер У.Баярсүрэн, М.Гоомарал, Байгаль хамгаалагч Н.Цэндсүрэн, Б.Есүхэй, БОХУБайцаагч И.Наранбаатар нар хамтран гүйцэтгэсэн. 1 дүгээр сарын 21-нд 2020 онд үйлдвэрийн болон ахуйн зориулалттай хэрэглээний мод, түлээ бэлтгэх хуваарийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан.

Тариалангийн зориулалттай 1 иргэний 50 га газрыг 1 аж ахуйн нэгжид шинээр 1 аж ахуйн нэгжид албан конторын зориулалтаар 0,4 га газрыг баталгаажуулахаар 3 дугаар авч гэрээ байгуулан гэрчилгээ олгосон. Мөн газар эзэмших эрхээ шилжүүлэх 2 аж ахуйн нэгжийн 10 нэгж талбар 1 иргэний 1 нэгж талбарын хүсэлтийг хүлээн аваад байна. Газрын кадастрын мэргэжлийн байгууллагатай хамтран 1 аж ахуйн нэгжийн үтрэм, 20 иргэний эзэмшилт өмчлөлийн газарт хэмжилт хийлгэн зургийг хүлээлгэн өгч Лм программд суулгаж, Лм программаас 10 иргэний зураг хэвлэж улсын бүртгэлийн газарт явуулсан.

Сум хөгжүүлэх сангаас зээл авсан зээлдэгчдийг зээлдэгч тус бүрээр гарган, хугацаа хэтэрсэн зээлүүдийн 13 зээлдэгчтэй холбоо барьж, зээл үлдэгдлээ төлөх шаардлага хүргүүлсэн. 2019 оны сүүлийн хагас жилийн арьс ширний баримтуудыг

хүлээн авч бүртгэн, программд шивж, төмс, хүнсний ногоо, улаан буудайн сортын тайланг гаргаж ХХААГ-т хүргүүлсэн.

Жавхлант сум:

Сумын Засаг даргын захирамжаар 2020 оны цэргийн шинэчилсэн тоо бүртгэл хийж аймгийн цэргийн штабт судалгаа мэдээллийг гарган хүргүүлэн ажиллалаа. Сумын хэмжээнд 1-р зэргийн бэлтгэл үүрэгтэн 153, 2-р зэргийн бэлтгэл үүрэгтэн 299, дүйцүүлэх-26, мөнгөн төлбөр-7, тайван цагт цэргийн албанд 07- 33, офицер-1, цэрэгт бүртгэлтэй эмэгтэйчүүд 11 байна.

Засаг даргын Тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн Хурал хамтран Монгол Улсын Үндсэн хууль батлагдсан түүхт 28-н жилийг тохиолдуулан үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт, шинээр батлагдсан хуулийг иргэд олон нийтэд сурталчилан таниулах, төрийн албан хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор төр төсвийн байгууллагуудын албан хаагчдын дунд АСТ тэмцээн зохион байгуулж тэмцээний нэгдсэн дүнгээр тэргүүн байрт С.Оюунчимэг эрхлэгчтэй 1-р цэцэрлэг, дэд байрт А.Шинэ-Од даргатай эрүүл мэндийн төвийн хамт олон тус тус шалгарлаа.

Багийн иргэдийн нийтийн хурал хуралдаж төр төсвийн байгууллагуудын дарга эрхлэгч, багийн Засаг дарга нар 2019 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг иргэдэд танилцуулж тайлан болон цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг иргэдээс авч ажиллалаа. Сумын Засаг дарга Ж.Отгондалай цаг үеийн мэдээллээр иргэдэд мэдээлэл хийж санал хүсэлтийг сонслоо.

Мөн 2021 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийх ажлын санал авах хуудсыг иргэд олон нийтэд тарааж ажилласан.

Засаг даргын Тамгын газар “Амьдралын зөв хараа” ТББ-ын тэргүүн лектор Ц.Даваадоржтой хамтран төрийн албан хаагчид болон иргэдийн дунд “ХҮЧИРХЭГ ХАМТ ОЛОН” сэдэвт хувь хүний хөгжлийн талаарх сургалтыг зохион байгууллаа.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуралдаж Сум хөгжүүлэх сангаас олгох зээлийн тэргүүлэх чиглэлийг баталсан бөгөөд Мал аж ахуйн гаралтай түүхий эд, сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах жижиг үйлдвэрлэл, өрхийн аж ахуйн үйлдвэрлэл, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэх боловсруулах, өгийн аж ахуй эрхлэх гэсэн чиглэлүүдийг батлаад байна.

Мал эмнэлгийн ерөнхий газраас малын гэрчилгээний нэгдсэн системийн программыг улсын хэмжээнд нэвтрүүлэн хэрэгжүүлж эхэлсэнтэй холбогдуулан сумаас зах зээлд борлуулах мал, мах, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээг цахимаар бүртгэн ариун цэврийн гэрчилгээ олгож байна.

2019 оны Арьс ширний урамшуулалын материал хүлээн авах ажлыг орон нутагтаа зохион байгуулж 118 малчин өрхийн үхэр, хонь, ямааны арьсны падан хүлээн авч программд оруулан холбогдох материалыг Аймгийн ХХААГазарт хүргүүлэн ажиллаж байна.

Иргэдийн амьдрах ая тухтай орчинг бүрдүүлэх, сумын өнгө үзэмжийг сайжруулах, амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй халдварт өвчнөөс сэргийлэх зорилгоор сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төр төсвийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын албан хаагчид, иргэд орчныхоо хогийг цэвэрлэж, нийт 7.5 тн хогийг төвлөрсөн хогийн цэгт хаяж зайлуулсан. Мөн Шарын голын 3-н замын уулварын түр хогийн цэгийг хог хаягдал, сумын төвөөс уг уулзвар хүртэлх зам дагуух газрын хогийг цэвэрлэсэн.

Нийслэлийн Онцгой байдлын Газар, Дэлхийн Зөн Монгол Олон Улсын байгууллага хамтран ЕБСургууль болон Сургуулийн өмнөх боловсролын багш нарыг аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, аврах, өөртөө болон бусдад анхны тусламж үзүүлэхэд сургах, газар хөдлөлтийн үед аюулын дохиогоор хэрхэн гарах зэргийг зааж сургах дадлагажуулах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор зохион байгуулагдсан «Гамшгийн эрсдлээс урьдчилан сэргийлье» сэдэвт сургалтанд ЕБС, Цэцэрлэгийн 9 багшийг хамрууллаа.

Засаг даргын Тамгын газар, Дэлхийн Зөн Монгол Олон улсын байгууллага хамтран Өрхийн хөгжил-90 хөтөлбөрт хамрагдсан 30 өрх, төр төсвийн байгууллагын албан хаагчдын дунд "Хувь хүний хөгжил ба хандлага" сэдэвт сургалтыг зохион байгуулж 64 иргэн хамрагдлаа.

Тус сумын 85-аас дээш настай 4 ахмадын судалгааг гарган аймгийн ЗДТГ-т хүргүүлэн ажиллалаа.

Сумын Засаг дарга ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй Моностой 2-р багийн хөдөөгийн малчин өрхүүдээр явж өвөлжилт болон цаг үеийн байдалтай танилцан 3 өдөр ажиллалаа.

ХАОСТОоллого 2020 оны 01 сарын 9-нөөс эхлэн 2020 оны 01 сарын 15-ны хооронд явагдаж сумын хэмжээнд нийт 70 өрхийн 270 хүнийг уламжлалт буюу цаасаар судалгаа авч тооллогонд хамруулан ажилласан.

Тухайн сард нийт 227 хүнд үзлэг хийгдсэнээс гэрийн идэвхитэй эргэлтээр 26, амбулаторын үзлэгээр 77, урьдчилан сэргийлэхээр 96, идэвхитэй хяналтаар 28 эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж зөвөлгөө өгч ажиллалаа.

Сурагчдын амралтаар эцэг эхийн хараа хяналтыг нэмэгдүүлэх зорилгоор анга удирдсан багш нар гэрээр зочлох хөтөлбөрийг хэрэгжүүлэн зорилтод бүлгийн нийт 87 суралцагчдад хяналт тавин ажиллаа. Мөн томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, аймгийн болон сумын засаг даргын захиралмж зэрэг мэдээллүүдийг тарааж эцэг эхтэй нь уулзаж хагас жилийн дүн танилцуулан сургуульд хэлэх санал хүсэлт, сурагчийн зан харилцааны өөрчлөлт, гэрийн даалгавар тогтмол хийж байгаа талаар ярилцаж мэргэжлийн багш нараас даалгаварыг нь авч сурагчдад хүргэж ажиллалаа.

Сургуулийн өмнөх боловсролын багш ажилчид хамтран 20-30 ш сургалтын хэрэглэгдэхүүн, бодит үзүүлэнг гарын доорх материал ашиглан хийж сургалтын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, хөдөө ажиллах ажлын хэсэгт малчдын 2-5 настай хүүхдүүдэд зориулсан 140 ширхэг гарын авлага, тараах материал боловсруулж өгч 1 сарын "Жавхлантайн мэдээ" сонинг эрхлэн гаргалаа.

Сант сум

Сумын хэмжээнд энэ онд 40920 эх мал төллөхөөс 1-р сарын 25-ны өдрийн байдлаар үнээ 16,эм хонь 23,эм ямаа 48 бүгд 87 эх мал төллөж гарсан төл 100 хувь бойжиж байна. Том малын хорогдол үхэр 3, хонь 6 бүгд 9 том мал хорогдсон дүнтэй байна.

Цэргийн тоо бүртгэл зохион байгуулах тухай сумын Засаг даргын А/01 тоот захирамжаар ажлын хэсэг томилогдон ажиллаж 2020 оны цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийг 01-р сарын 08-наас 23-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сумын хэмжээнд цэргийн бүртгэлд хамрагдалт 93,6 хувьтай явагдсан байна.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллого 01-р сарын 09-нөөс 15-ны хооронд зохион байгуулагдаж сумын хэмжээнд нийт 80 өрхийн 245 иргэнийг тоолж бүртгэсэн байна. Хяналтын тооллогод сумын төвийн 4 өрх, хөдөөгийн 4 өрх нийт 8 өрх хамрагдлаа.

ЗДТГ-ын ёс зүйн зөвлөл нь 01-р сарын 09-ний өдөр хуралдаж 2020 онд хийх ажлын төлөвлөгөө боловсруулан батлууллаа. Төлөвлөгөөний дагуу ЗДТГ-ын албан хаагчдын харилцаа хандлагын талаар асуумж бэлтгэж 50 иргэнээс санал асуулга авч нэгтгэн байгууллагын хамт олны хурал дээр танилцууллаа.

Сумын Засаг даргын орлогч, ЗДТГ-ын төлөөлөл, ЭМТ-ийн төлөөлөл оролцсон орон тооны бус хяналтын зөвлөл ерөнхий боловсролын сургуулийн эрүүл ахуй, халдвар хамгаалал, үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт, дотуур байр болон сургуулийн дотооды норчинд хяналт шалгалт хийж зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ. ЕБС-ийн дотуур байранд 42 сурагч, үдийн цай хөтөлбөрт 1-5 дугаар ангийн 146 сурагч хамрагдаж байна.

Хүүхдийн тусламжийн утас 108 болон сумын гэр бүл хүүхэд хамгааллын хамтарсан багт ирсэн 2 иргэний гомдлыг хүлээн авч холбогдох этгээдийг зөрчил хянан шийдвэрлэх хугацаанд шалгаж арга хэмжээ авч ажиллах талаар сумын

цагдаагийн хэсэгт албан тоот хүргүүллээ. Хамтарсан багаар 2 хүүхэдтэй өрх толгойлсон 1 эхэд үйлчилгээ үзүүлж 276500 төгрөгийн дулаан хувцас, хөнжил зэрэг эд материалын тусламж дэмжлэг үзүүллээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн өдөр, шинэ “Үндсэн хууль” батлагдсаны 28 жилийн ойн хүрээнд “Үндсэн хуулийн тухай ойлголт, түүхэн замнал” сэдэвт сургалт мэдээллийн ажлыг зохион байгуулж 27 иргэн хамрагдлаа. “Монгол Улсын Үндсэн хууль” сэдэвт гарын авлага бэлтгэж 45 иргэнд тараасан байна. Мөн сумын орон нутаг судлах танхимаас сум орон нутагт ажиллаж амьдарч байсан АИХ-ын 3 депутатуудын намтар түүхийг өгүүлсэн мэдээллийг Ивэн голын хүүхдүүд цахим группт байршуулж сурталчиллаа.

Сайхан сумын Татварын тасагтай хамтран Татварын хууль тогтоомж, хөнгөлөлт чөлөөлөлтийн талаар сургалтыг 1-р сарын 23-ны өдөр зохион байгуулж 6 аж ахуйн нэгж, 28 иргэн хамрагдлаа.

Сумын цагдаагийн хэсгээс төрийн албан хаагчдын дунд "ЯТГАХ ТУСАМ НЯГТАЛ" сургалтыг зохион байгуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдал, Залилангийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар Сайхан сум дахь Цагдаагийн хэлтсийн холбогдох албан хаагчид мэдээлэл хийлээ.

“Дэлхийн Зөн” ОУБ-ын Сэлэнгэ нутгийн хөтөлбөрийн газартай "Жинхэнэ эр хүн" аавуудын сургалтыг зохионб айгууллаа. Сургалтанд Хувь хүний хөгжлийн институтын захирал М.Алтанцэцэг, сургагч багш н.Хосбаяр нар 8 цагийн лекц уншиж 37 иргэнийг хамрууллаа. Сургалтанд хамрагдсан аавууд гэр бүл дэх аавуудын оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, өрх гэрээ хүчирхийлэлгүй байлгаж үр хүүхэд, хань ижилдээ халамжтай, үлгэрлэн чиглүүлэгч аавууд байх, хорт зуршил хэрэглэдэг аавууд муу зуршлаасаа ангижирцгаая хэмээн уриаллаа.

Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын улсын тооллогын бэлтгэл ажлыг хангах үүднээс суманд бүртгэлтэй соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын нэгдсэн бүртгэлийг шинэчлэн гаргалаа. Сумын хэмжээнд соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч 25 иргэн бүртгэгдсэн байна.

Сүхбаатар сум:

Тус сумын Засаг даргын Тамгын газар нь шинэ жилийн баярын нийтээр амрах өдрүүдэд албан байгууллагын цахилгаан, усан хангамж өрөө тасалгааны цоож цонхны хамгаалалт зэргийн бүрэн бүтэн байдлыг шалган ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарийг гарган 2019 оны 12 дугаар сарын 29-01 өдрүүдэд нийт тус сумын харьяа төр төсвийн байгууллагуудын албан хаагчид албан байгууллагадаа хариуцлагатай жижүүр гарч ажиллалаа.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2019 оны А/450 тоот захирамжийн дагуу цэргийн шинэчилсэн бүртгэл зохион байгуулах сумын Засаг даргын захирамжийн дагуу цэргийн бүртгэлийг зохион байгуулан ажиллаж холбогдох мэргэжилтнүүдийг сургалтад хамрууллаа.

Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 28 жилийн ойн хүрээнд Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газар нь албан хаагчдад Монгол Улсын Үндсэн хуулийг сурталчлан 2019 оны 11 дүгээр сарын 25-ны төрийн мэдээлэл сэтгүүлд хэвлэгдэн гарсан Монгол Улсын үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт, нэмэлт өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын талаар танилцуулж сургалт зохион байгууллаа.

Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 28 жилийн ойн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, хүн төрөлхтний соёлын өв болох шагайн харвааг хөдөө орон нутагт хөгжүүлэх, уламжлалт өв соёлыг залуу хойч үедээ өвлүүлэх, сонирхон хичээллэж буй харваачдын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн ЗДТГ, Сүхбаатар сумын ЗДТГ, аймгийн Шагайн харвааны Баян хан холбоо, Ерөнхий боловсролын Спорт сургуультай хамтран “2020 оны нээлтийн харваа” тэмцээнийг 2020 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгууллаа. Тэмцээн Багийн харваа, Цуваа харваа

гэсэн 2 төрлөөр явагдсан ба 13 багийн 104 харваачид цэц мэргэнээ сорин өрсөлдлөө.

Аймгийн Татварын хэлтсээс хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн тайлан хүлээн авах, бүрдүүлэх материалын талаар болон 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Татварын Ерөнхий хууль, ХОАТ-ын тухай хуулийн өөрчлөлт, Е-баримт аппликейшны ашиглалтын талаарх сургалт зохион байгууллаа.

Сум хөгжүүлэх сангийн зээл гарахтай холбогдуулан сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж хуралдаж нийт 30 төсөл ирсэнээс 17 төслийг сонгон шалгаруулж 17 иргэнтэй зээлийн гэрээ хийж ажиллалаа.

Сумын бренд бүтээгдэхүүн шалгаруулж 7 аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүний танилцуулга, түүхий эдийн мэдээг Хүнс, хөдөө аж ахуйн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүллээ.

Аймгийн мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар хамтран хүнсний худалдаа, нийтийн хоолны газруудад хяналт шалгалт хийж гахайн мах худалдан борлуулаж байсан 3 аж ахуй нэгж, 3 иргэний гахайн махнаас авсан дээжийг Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторид хүргэж өгч ажиллалаа.

Тус сумын харъяат иргэд “Хуулийн талаар ойлголт, мэдлэг, мэдээлэл дутмаг байна” гэх Цагдаагийн газрын мэдэгдэлийн хүрээнд Алтанбулаг сумын Байгаль орчны байцаагч-байгаль хамгаалагч, Хууль эрх зүйн асуудал хариуцсан ажилтан нарын хамт Хонгор морьтын 1-р багийн 20 иргэнд одоогийн мөрдөгдөж байгаа ойн тухай хууль, зөрчлийн тухай хуулийн талаар мэдээлэл өгч сурталчилгаа хийн санамж тараалаа.

Ерөнхий боловсролын 3-р сургуулийн захиралын гомдлын мөрөөр сургуулийн ойр орчимд их хэмжээний хог, хаягдал асгасан эзэн холбогдогчийг олж тогтоон ахуйн ослоос сэрэмжлэн хамгаалалтын тууз татаж, анхааруулга санамж бичин байршуулах шаардлага өгч хэрэгжүүллээ. Буур хээрийн 8-р багийн иргэний гомдлын мөрөөр ажиллан холбогдох эздийг байлцуулан асуудлыг шийдвэрлүүлж хариуг өөрт нь хүргүүлэв. Салхитын 3-р багийн иргэн Бороогийн мэдээлэл гомдолын дагуу зөгийн бал экспортлогч “Михачи” ХХК-н захирал Д.Оч-эрдэнийг байлцуулан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, менежментийн төлөвлөгөөгүй үйл ажиллагаа явуулж байгаа тул “Хяналтын хуудас”-аар эрсдэлийн үнэлгээг тогтоон зөвлөмж хүргүүлэв.

Шаамар сум:

2019 онд Улс, аймаг, сум орон нутгаас дэвшүүлсэн ажил, арга хэмжээний тайлан, мэдээ, судалгаа, нэгтгэлүүдийг баримтжуулан хавтаслаж, журмын дагуу архивын нэгж үүсгэн хадгалуулсан. Үүнд: Монгол Улсын Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2019 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан, мөн аймаг, сумыг 2019 онд хөгжүүлэх нийгэм эдийн засгийн үндсэн чиглэлийн төлөвлөгөө, тайлан гүйцэтгэл, төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилт зэрэг 17 нэр төрлийн тайлан болон сумын төсвийн байгууллагын тайлан нэгтгэл, Төсвийн шууд захирагч нарын хамтран ажиллах гэрээний биелэлт, сумын төрийн захиргааны албан хаагчдын үр дүнгийн гэрээний биелэлт, илтгэх хуудас, ажлын тайлан, 2019 онд авсан санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төлөвлөгөө, гүйцэтгэл, төсвийн хуваарь, зарцуулалтын тайлан, тушаал шийдвэрийн биелэлт зэрэг бодлогын болон үйл ажиллагааны баримт бичгүүдийг нэгтгэн архивт хүлээлгэн өгсөн.

“Хүн ам, орон сууцны 2020 оны Улсын ээлжит тооллого” эхлэхтэй холбогдуулан Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд 2019 оны 12-р сарын 24, 25-ны өдрүүдэд зохион байгуулагдсан бүсчилсэн 2 хоногийн сургалтанд багийн Засаг дарга нар хамрагдаж арга зүйн зөвлөгөө авч тоологын үеэр гарч болох аливаа эрсдэл, хүндрэлийн талаар санал бодлоо солилцож, тооллогоор хэрхэн ажиллах төлөвлөгөө гарган, сургалтаар олсон мэдлэгээ баталгаажуулах, бататгах зорилгоор

шалгалт сорил өгч тоологч, шалгагчаар ажиллах анхан шатны мэдлэг мэдээлэл авч ажиллалаа. Тооллогыг 2020 оны 01 сарын 09-өөс эхлүүлж, сумын дүнгээр нийт 126 өрх, 454 иргэн хамрагдсан.

2020 оны цэргийн тоо бүртгэлийг орон нутагт зохион байгуулж, сумын хэмжээнд ажиллаж, амьдарч буй 18-50 насны цэргийн 1, 2-р зэргийн бэлтгэл үүрэгтэн, цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүд, 65 хүртэлх насны дээд, 60 хүртэлх насны ахлах, 55 хүртэлх насны дунд офицерууд болон ахлагч нарын мөн зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдал, цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, шүүх шинжилгээний албанд ажиллаж байгаа тусгай албан хаагчдыг бүрэн хамруулахаар зохих арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Цэргийн тоо бүртгэлийг 2020 оны 01 дүгээр сарын 08-наас 2020 оны 01 дүгээр сарын 23-ны хооронд бүртгэж, багийн нэгтгэлүүдийг 2020 оны 01 дүгээр сарын 27-ноос хүлээн авч нэгтгэн сумын нэгтгэлийг хуваарьт хугацаанд хүргүүлэхээр ажиллаж байна. Урьдчилсан байдлаар бүртгэлд хамрагдвал зохих 1031 иргэнээс 2020 оны 01 дүгээр сарын 24 ны байдлаар 89.4 хувь буюу 913 иргэн бүртгэгдээд байна.

“Монгол Улсад Шинэ Үндсэн хууль” батлагдан мөрдөж эхэлсний 28 жилийн ойн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх үүрэг чиглэл ирүүлсний дагуу сумын ЗДТГ-аас Монгол Улсын Үндсэн хуулийн түүхэн замналыг харуулсан фото зурган самбарыг байршуулж, олон нийтэд Үндсэн хуулийн танилцуулга, түүхэн замнал, үүсэл хөгжлийн талаарх мэдээллийг хүргэн ажилласан. Мөн Шинэ Үндсэн хууль батлалцсан төлөөллийн гэр бүл ахмад настан Г.Зандангийн гэрт нь хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардууллаа. Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаар иргэдэд мэдээлэл хүргэх сургалтыг байгууллагын албан хаагчдын дунд зохион байгуулж, Үндсэн хуулийн өөрчлөлтийн талаарх зурагт хуудас, гарын авлагыг тэмцээн уралдаан оролцогчдод тараан сумын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулж, олон нийтэд түгээх ажлыг зохион байгууллаа. Уг арга хэмжээг угтан сумын аварга шалгаруулах Хүчит бөхийн барилдаан, оюутан залуучуудын дунд сагсан бөмбөгийн тэмцээнийг зохион явуулж 150 гаруй иргэд оролцлоо.

Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу “Агаар бохирдлын эх үүсвэрийн тооллого”-ыг орон нутагт зохион байгуулах ажлын хэсгийг сумын Засаг даргын 2020 оны А/08 тоот захирамжаар байгуулж, суманд үйл ажиллагаа явуулдаг 15-100 хүртэл квт-ын хүчин чадалтай халаалтын уурын зуухыг тоолох ажлыг 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр хийлээ. Суманд 15-100 квт-ын хүчин чадалтай 5 аж ахуй нэгж, албан байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Сумын алслагдсан багийн малчин айл өрхийн өвөлжилтийн бэлтгэл нөөцийг судлах, малчдад төр засгийн бодлого шийдвэрийг танилцуулах, малчдын санал хүсэлтийг хүсэлтийг сонсож, малчдад нэмэгдэл тэжээл тараах ажлыг зохион байгууллаа. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх төрийн бодлого шийдвэрийг таниулж, хар ангус үүлдрийн 4 бухыг нэмэгдэл тэжээлд оруулж, сайжруулагчаар ашиглаж байгаа цэвэр үүлдрийн бухны 8 төлд үзлэг хийхэд малын удам зүйн үнэлгээнд үржлийн удам, зүс, галбир, бие цогцос, үр төлийн чанар, өвөрмөц тогтоцын үзүүлэлтийг бүрэн хангаж байсан байна. Мөн мал эмнэлгийн үйлчилгээ, малчин өрхийн малын эрүүл мэндийн бүртгэлийн дэвтрийн хөтлөлтөд хяналтыг мал эмнэлгийн албаны Улсын байцаагч, малчид тариаланчдын зохицлын гэрээний талаарх мэдээллийг газар тариалан хариуцсан мэргэжилтэн нар танилцуулж, сумын Засаг дарга малчдын амьдрал ахуй, өвөлжилтийг даван туулахад төр засгаас шалтгаалах дэмжлэг тусламжийн талаар мэдээлэл хийж, багийн Засаг дарга нар өвөлжилтийн бэлтгэл нөөцийн судалгааг гарган авч өрх бүрт 1-3 кг нэмэгдэл тэжээл /загасан тос/-ийг олголоо. Үүнд: Дэлгэрхааны 1 дүгээр багийн 15, Охиндий 2 дугаар багийн 31, Дулаанхааны 3 дугаар багийн 13 нийт 59 малчин өрхөд хүрч ажилласан байна.

Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс шир бэлтгэн нийлүүлсэн сумын хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох тухай Засгийн газрын 2013 оны 394 дүгээр тогтоолын дагуу арьс ширээ тушаасан

иргэдийн малын тоо, тушаасан баримтыг нэг бүрчлэн нягтлан тулгаж, нэгтгэн холбогдох дээд шатны байгууллагын мэргэжилтэнд хүргүүллээ. Үүнд: Дэлгэрхааны 1-р багийн 10 малчин, Охиндий 2-р багийн 1 малчин үхрийн шир 242, хонины нэхий 470, ямааны арьс 332 ширхэг буюу нийт 1044 ширхэг арьс, шир, нэхий ташаасан байна.

Мал эмнэлгийн цахим систем нэвтэрч малчдад олгох гарал үүслийн гэрчилгээг цахимаар бүртгэх болсонтой холбогдуулан сумын малчин, мал бүхий 59 өрхийн 118 иргэнд танилцуулж, зурагт хуудсыг мэдээллийн самбар, цахим хуудаст байршуулан сумын МЭҮН-ийн эмч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч, гар утсанд нь цахим системийн аппликейшинг татан суурилуулж, бүртгэх аргачлалыг зааж, сургаснаар 2020 оны 01 дүгээр сарын 24 ны өдрийн байдлаар 9 иргэнд цахим гарал үүслийн гэрчилгээг хэвлэж олгоод байна.

“Атарчдын алдар” медалиар шагнагдах ахмад атарчдын судалгаа, шагналын тодорхойлолтыг багийн Засаг даргатай хамтран гаргаж хүргүүллээ. Үүнд: Улсын аварга хадланчид болох 14 ахмад атарчдын материалыг хүргүүлсэн.

Шаамар сумын 2019 оны жилийн эцсийн малын тоог livestock программаас татан авч файл үүсгэн хадгалж авсан ба МЭҮН-үүдийн 2020 онд үйлчилгээ үзүүлэх малчин, мал бүхий өрх болон тэдний малын тоог малын эмч нартай тулгаж, товчоог нь тус бүрээр нь хийлгэн сумын Засаг даргад танилцуулан батлуулсан.

Сум хөгжүүлэх сангийн 2019 оны 12 дугаар сарын эргэн төлөлтийн мэдээг аймгийн ХХААГ-т хүргүүлж, 9 зээлдэгчийн мэдээллийг сум хөгжүүлэх сангийн бүртгэл, хяналт нэгтгэлийн программд шивж баталгаажуулсан.

Хүдэр сум:

Тайлант сард Засаг даргын зөвлөлийн хурал 2 удаа хуралдаж цаг үетэй холбоотой асуудлыг хэлэлцлээ. Хуралдаанаар Цэргийн бүртгэл хийгдэж эхлэхтэй холбоотой Багийн Засаг дарга нарт үүрэг чиглэл өглөө. Аймгийн Засаг дарга иргэдтэй хийх уулзалт 1-р сарын 20-ээс хойш зохион байгуулагдана үүнтэй холбоотой зохион байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэх, Замын тэмдэг тэмдэглэгээг хийлгэх, Төрийн албан хаагчдын цалинг нэмэхтэй холбоотой төсөвт зохицуулалт хийх зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Өвөлжилтийн бэлтгэл байдалтай танилцах, малчдад эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэх зорилгоор малчдын хотод ажиллаж, 2019 оны хийж хэрэгжүүлсэн ажил цаашид хийх ажлын талаар танилцуулсан нь малчдын сэтгэлд хүрсэн ажил боллоо.

Монгол Улсын Анхдугаар Ардчилсан Үндсэн хууль батлагдсны 28-н жилийн ойг тохиолдуулан иргэд, төрийн албан хаагчдын дунд Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт, үзэл санааг сурталчилах, сургалтыг зохион байгуулан ажиллалаа. Уг сургалтанд 76 төрийн албан хаагч, 18 иргэн хамрагдлаа.

Хүн амын орон сууцны улсын тооллого явагдаж 2 багийн 70 өрх тоологдож статистикийн хэлтэст хүргүүлсэн.

Шинээр хэрэгжиж байгаа Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хөнгөлөлт,чөлөөлөлтийн талаар 2 удаа сургалт зохион байгуулж сургалтанд 59 иргэн хамрагдсан байна. Мөн хөнгөлөлт, чөлөөлөлтийн тайланг хянаж хүлээн авч эхлээд байна. 2019 оны жилийн эцсийн тайлангийн ирцийг хангуулахаар бүртгэлтэй 175 аж ахуй нэгжид утсаар тайлангийн хугацааны талаар мэдэгдсэн. Хөндлөнгийн мэдээлэлээр ирсэн 6 иргэний тайланг хянаж хүлээн авсан. 2019 оны баримт бичгээ үдэж архивт хүлээлгэн өгсөн.

Дэлхийн зөн олон улсын байгуулагатай хамтран ЕБСургууль, 1-р цэцэрлэг "Хүмүүжлийн эерэг арга" сургалтыг зохион байгуулж сургалтанд 360 эцэг эх хамрагдаж эерэг дулаан уур амьсгалтай сургалтыг зохион байгууллаа.

Сургуулийн өмнөх сургалтын байгууллагаас сургалтын сайжруулсан хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, гарч буй алдаа дутагдал сэдэвт сургалтыг зохион байгуулах, Эрхлэгч-1 арга зүйч-1, бүлгийн багш-8 туслах багш -7 нярав-1 тогооч -2 жижүүр-1, үйлчлэгч-1 нийт 22 ажиллагсад оролцлоо.

2020 оны 01 сарын 20 өдрийн байдлаар 236 хүүхдээс 122 хүүхэд хүлээн авч 51 хувийн ирцтэй байна. Шалтгаангүй ирээгүй хүүхдийг тодруулах, хамран сургалтыг нэмэгдүүлэх үүрэг чиглэлийг бүлгийн багш нарт өгөөд байна.

Сумын хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээг стандартын дагуу чанартай үзүүлж иргэдээс гомдол санал гаргалгүй ажиллаж байна. Тайлант хугацаанд эмнэлэгт хэвтсэн 9, ор хоног 67, нас баралт 2, бүгд дуудлага 76, амбулаторийн үзлэг 269 хийгдсэн.

1-р сард дархлаажуулалтад хамрагдвал зохих 39 хүүхдийг бүртгэн авч дархлаажуулалтад хамруулж байгаа ба явуулын түр оршин суугчдын 1 хүүхдийг дархлаажуулалтад хамруулаа. Энэ сард 7 төрлийн шинжилгээнд 100 иргэн хамрагдав. Цусны ерөнхий шинжилгээ, элэгний В,С илрүүлэх шинжилгээнд 5,Хеликобактер илрүүлэх шинжилгээнд 17, элэгний үйл ажиллагаа /биохими/ 18, сахар /захын судсанд/ 8, ШЕШ 29, цусны бүлэг резус бүлэг 8, БЗДХӨ 15 иргэн тус тус хамрагдсан байна.

Дэлхийн зөн Сэлэнгэ орон нутгийн хөтөлбөрөөс “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сэдвээр 30 эцэг эхэд 2 өдрийн турш 16 цагийн сургалтыг багаар ажиллуулан сургалт зохион байгуулж 27 ээж 3 аав хамрагдсан байна. Хүүхэд гэр бүл хамгааллын хамтарсан багийн 2019 оны тайлан, багийн гишүүдийн мэдээллийг Хүүхэд гэр бүл хөгжлийн газарт хүргүүлэв. 2019 оны хүн амын тоог нэгдэн гаргав.

Хүүхдийн тусламжийн утас 108 утсанд ирүүлсэн 1 дуудлагын дагуу дуудлага өгсөн хүүхэд иргэдтэй уулзаж нөхцөл байдлын үнэлгээ хийж, хүүхдийн бүртгэлийн маягт хөтөлж хүчирхийлэл үйлдсэн этгээдэд зөрчлийн хуулийн дагуу арга хэмжээг авахуулж ажилласан.

Сумын “ Малчны оргил” хоршоо төлөөлөгчөөр дамжуулан “Дарханы нэхий” үйлдвэрт 34 малчин өрхийн хонины нэхий -81, үхрийн арьс-222 нийт 303 ширхэг арьс ширний урамшуулалд хамрагдах падаан материалыг бүрдүүлэн Аймгийн ХХААГ-т хүргүүлэн өгсөн. Малын удмын сангийн программд шивэлтийг хийж гүйцэтгэсэн.

Мал эмнэлгийн үйл ажиллагаанд хяналт тавих ажлын нэгдсэн удирдамжийн дагуу 2020 оны малын эрүүл мэндийн гэрчилгээ олгох цахим системд амжилттай нэвтрэн оны эхнээс 20 удаагийн гэрчилгээг цахимаар шивж гарган, иргэдэд хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлэн ажиллаа. Үүнд: 3 толгой адуу, 5 үхэр, 6 хонь, 480 кг адууны мах, 1430 кг үхрийн мах, 160 кг хоньны мах, 50 л сүүнд эрүүл мэндийн гэрчилгээ олгов. Мөн холбогдох, бусад мэдээ бичиг баримтыг цаг хугацаанд нь гаргаж өгч ажиллалаа..

“Хаягжуулалтын тухай хууль”-ын дагуу шинэ хаягаар 22 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад кадастрын зургаар үйлчилгээ үзүүлж ажиллалаа. Мөн“Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль”-ын 7.1 дүгээр зүйлд заасны дагуу кадастрын зураг хийлгэх хүсэлт гаргасан 58 иргэдийн гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газар, өвөлжөөний газар болон үл хөдлөх эд хөрөнгөд кадастрын эрх бүхий байгууллагаар хэмжилт, зураглал хийлгэн ажиллалаа.Худалдах, худалдан авах гэрээний үндсэн дээр өмчлөх эрхээ шилжүүлж буй 5 иргэний өргөдлийг хүлээн авч эрх шилжүүлэх үйл ажиллагааг хийгээд байна.

Сумын Засаг даргын 2020 оны 02 тоот захирамжаар сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсгийг томилж, 2019 оны 01 дүгээр сарын 14,15 ны өдрүүдэд тус сумын Ойн санг гэрээгээр эзэмшигч аж ахуйн нэгж, ойн нөхөрлөлийн 2019 онд Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтэнд үнэлгээ өгч, нийт 32, Ойн нөхөрлөл 15 дүгнэгдэхээс 15 дүгнэгдсэн байна.

Хүдэр суманд үйл ажиллагаа явуулж байгаа 30 хөрөө рамын үйл ажиллагааг зогсоож холбогдох бичиг баримтын бүрдэлтийг хангуулхаар мэдэгдэл өгч ажиллаа.

Мод бэлтгэлийн мэрэгжлийн байгууллагын хаягдал үртэс болон иргэдийн хаясан ахуйн хог хаягдлыг” Хүдэр бумбатын овоо”ХХК,”Шинэ Хүдэр өгөөж” ХХК-ий техникээр цэвэрлүүлж орчны бохирдлыг багасгалаа.

Түшиг сүм:

Хүн ам орон сууцны улсын тооллогын 2020 оны үйл ажиллагаанд тоологч, шалгагч нарыг бэлтгэх сургалтанд хамруулж сумын тооллогын комиссын бүрэлдэхүүн, сумын болон багийн түр товчоог байгуулан тооллогын ажлыг хийж гүйцэтгэлээ. 2020 оны Хүн ам орон сууцны улсын тооллогыг Түшиг сумын хэмжээнд сонгогдсон нийт 60 өрхийн 240 хүнийг тооллогод хамрууллаа.

Үүнээс:15-59 насны 1 эрэгтэй,1 эмэгтэй 0-14 насны 1эрэгтэй хүүхэд, Швед-д 0-14 насны 1 эрэгтэй хүүхэд, 15-59 насны 1 эрэгтэй хорих ангид хүмүүжиж байна. Японд 15-59 насны 1 эрэгтэй,1 эмэгтэй нийт 123 иргэн байнга оршин суугаа буюу түр эзгүйгээр тооллогод хамрагдсан байна.

2019 оны жилийн эцсийн мал тооллогоор сумын хэмжээнд 59470 толгой мал тоологдсон ба 111 малчин өрх, 172 мал бүхий өрх тоологдож тус суманд мал эмнэлэгийн үйл ажиллагаа явуудаг 3 мал эмнэлэг үржлийн нэгжүүдэд малчин болон мал бүхий өрхийн малыг тэнцүү хувиарлан өгч мөн малын нэгдсэн систем цахим сүлжээнд холбогдсоноор малын гарал үүслийн бичгийг цахим хэлбэрээр ажлын цагаар олгон ажиллаж байна. Мөн Улс, аймгийн сайн малчин, алтан төлийн эзний материалыг бүрдүүлэн холбогдох газруудад явууллаа.

2019 оны ургацаас 2020 оны хавар тариалахаар аж ахуй нэгж, иргэдийн өөрсдийн нөөцөлсөн улаанбуудайн үрийн судалгааг авч, Сумын хэмжээнд 420 тн улаанбуудайн үрийн нөөцтэй, шаардагдах үрийн хэмжээ 801,7 тн хэрэгтэй байгаа гэсэн судалгааг гаргасан байна. “Улсын аварга тариалач” цол тэмдэгээр 1 хүнийг шагнуулахаар материалыг нь Хүнс, Хөдөө аж ахуйн газарт хүргүүлж ажиллалаа.

Сумын эрүүл мэндийн төв энэ хугацаанд нийт 253 үзлэгээс урьдчилан сэргийлэх үзлэгээр 102 буюу 40 хувь, гэрийн идэвхтэй эргэлт 81 буюу 34 хувь , түргэн тусламжийн 26 осол гэмтлийн өвчлөл 1 тохиолдол бүртгэгдлээ. Жирэмсэн 2 эхийг аймгийн нэгдсэн эмнэлгийн төрөх тасагт хүлээлгэн өгч төрүүлсэн. Эхний 3 сартай жирэмсний хяналтанд 2 буюу 100 хувь хүлээн авч одоогоор 15 жирэмсэн эх хяналтанд хянагдаж байна. Товлолын дархлаажуулалтанд 39 хүн хамрагдаж дархлаажуулалтын дараах урвал хүндрэл гараагүй болно.

Нийгмийн даатгалын санхүүжилтийн 4 төрлийн тусламж үйлчилгээнд одоогоор сэргээн засах тусламж үйлчилгээнд 9, оношлогоо шинжилгээнд 32, өдрийн эмчилгээнд 4, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээнд 10 хүн тус бүр хамруулан ажиллаж байна.

ХЯНАСАН

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ө.СУВДАА

БОЛОВСРУУЛСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ш.ЭНХМАА